



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



2007
жилийн тайлан



Олон улсын
хөрөнгийн зах зээл дээр

75 сая ам.долларын

бонд гаргасан

МОНГОЛЫН АНХНЫ

аж ахуйн нэгж



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

TRADE & DEVELOPMENT BANK OF MONGOLIA

Хэтийн зорилго

ХХБ нь Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч, олон улсын шилдэг туршлагуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлсэн, олон талын үйл ажиллагаатай банк бөгөөд харилцагч үйлчлүүлэгч, хамтрагч түншүүдийнхээ санхүүгийн сайн сайхан, тогтвортой байдалд хүрэхэд тууштай, хариуцлагатай туслагч, итгэл найдварыг нь хүлээсэн түнш нь байсаар байх болно.

Эрхэм зорилго

ХХБ нь Монгол улсын олон талт үйл ажиллагаатай, тэргүүлэх зэргийн банкны хувьд том, жижиг дунд, жижиг харилцагчдын зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн, үнэ цэнэтэй банкны үйлчилгээг хөгжүүлэн хүргэж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг байнга, хамгийн өндөр түвшинд байлгахад зорин ажиллана. Бид бүхний амжилт ололт шилдэг сайн үйлчилгээ, өндөр мэргэжлийн боловсон хүчин, хамтын удирдлагын дээд зэргийн арга барилд үндэслэх болно.


Moody's Investors Service

- УХ, БХ* Татан төвлөрүүлсэн хөрөнгө (гадаад валютаар)	B2/NP
- УХ, БХ Татан төвлөрүүлсэн хөрөнгө (дотоод валютаар)	Ba1/NP
- УХ, БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (гадаад валютаар)	Ba2/NP
- УХ, БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (дотоод валютаар)	Ba1/NP
- Барьцаагүй үнэт цаас (гадаад валютаар)	Ba2
- Хоёрдогч үнэт цаас (гадаад валютаар)	Ba2
- Хэтийн төлөв	тогтвортой

* - Урт хугацаат, богино хугацаат

АГУУЛГА

- Ерөнхийлөгчийн илгээлт
- Гүйцэтгэх захирлын илгээлт
- 2007 оны ололт амжилтууд
- Банкны бүтэц
- Банк санхүүгийн салбарын тухай
- Оны онцлох үйл явдлууд
- Санхүүгийн үзүүлэлтүүд
- Байгууллагын банкны үйлчилгээ
- Иргэдийн банкны үйлчилгээ
- Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ
- Жижиг, дунд байгууллагын банкны үйлчилгээ
- Хөрөнгө зохицуулалтын удирдлага
- Эрсдэлийн удирдлага
- Хүний нөөцийн удирдлага
- Аудитын тайлан
- Корреспондэнт банкууд
- Хаяг



▶▶ Харилцагч нартаа хамгийн урт хугацааны санхүүжилтийг хамгийн бага хүүтэйгээр олгох боломжийг бүрдүүлэхийн тулд ХХБ нь Монгол улсаас анх удаа Олон улсын санхүүгийн зах зээлд бонд гаргах 150 сая ам.долларын хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний 75 сая ам.доллартой тэнцэх хэмжээний бондыг амжилттай борлууллаа. Энэ хөтөлбөрт Moody's Investor Service гадаад валютаар гаргасан барьцаагүй үнэт цаасны Ba2 үнэлгээг өгсөн ... ◀◀

ЕРӨНХИЙЛӨГЧ РАНДОЛФ КОППА

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ

ХХБ Монголын ард түмэнд санхүүгийн үйлчилгээг хүргэн ажилласны 17 жилийн ой 2007 онд тохиосон билээ. Монголын хамгийн ууган арилжааны банкны хувьд банк, санхүүгийн зах зээл дэх тэргүүлэх байр сууриа хадгалан, бахдам амжилтаар дүүрэн байсныг дурьдахад таатай байна. Банкны нийт активын хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 32.1 хувиар өсч, 563.2 тэрбум төгрөгт, татварын дараах цэвэр ашиг 39.3 хувиар өсч, 16.4 тэрбум төгрөгт хүрсэнээр нь дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 29.8 хувьд хүрлээ.

ХХБ нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжин ажилладаг ба тайлант онд эдийн засгийн салбар дахь томоохон үйл ажиллагааг санхүүжүүлэх гол бодлогоо баримтлан ажиллалаа. Том харилцагч нарт олгосон зээлийн багц 278.8 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны нийт зээлийн 72 хувийг дангаар эзэлж байна. Банк нь уул уурхай, шатахууны импорт, аж үйлдвэр, барилга, тээвэр, бөөний болон жижиглэн худалдаа гэх мэт улс орны эдийн засгийн гол салбаруудыг түлхүү санхүүжүүлсээр байна.

Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчид болон хувийн хэвшлийнхэнд зориулан жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрүүд болон Дэлхийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны банкнаас санхүүжүүлсэн төслүүдэд амжилттай оролцож хамтран ажиллалаа.

Мөн бид зээлийн хяналт, шинжилгээний стандартыг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулахад онцгойлон анхаарч ажилласны үр дүнд банкны зээлийн багцын чанар дээшилснийг дуулгахад таатай байна. Тайлант онд чанаргүй зээлийн хэмжээ 30 хүртэл хувиар буурч, 7.9 тэрбум төгрөгт хүрсэн нь чанаргүй зээлийн хэмжээг нийт зээлийн 2.0 хувь болгон бууруулсан байна.

Харилцагч нартаа хамгийн урт хугацааны санхүүжилтийг хамгийн бага хүүтэйгээр олгох боломжийг бүрдүүлэхийн тулд ХХБ нь Монгол улсаас анх удаа Олон улсын санхүүгийн зах зээлд 150 сая ам.долларын бонд гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний 75 сая ам.доллартой тэнцэх хэмжээний бондыг амжилттай борлууллаа. Энэ хөтөлбөрт Moody's Investor Service гадаад валютаар гаргасан барьцаагүй үнэт цаасны Ba2 үнэлгээг өгсөн бөгөөд бондыг худалдаж авах захиалга арилжигдах дүнгээсээ 9 дахин давж, 13 орны 96 хөрөнгө оруулагчид худалдаж авлаа. Харилцагч нартаа хамгийн таатай нөхцөлтэй санхүүгийн үйлчилгээг хүргэх, тогтвортой байдал, хурдацтай өсөлтийг хангахын тулд ХХБ олон улсын хөрөнгийн зах зээлд үргэлжлүүлэн оролцохыг цаашид зорих болно.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн интеграци нь Монгол улсад ихээр нөлөөлсөөр байна. Өргөжиж буй хөрөнгийн зах зээлд арилжааны банкуудын өрсөлдөөн, гадаадын байгууллагууд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагуудын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх байдал дотоодын зах зээлд ажиглагдлаа. Нөхцөл байдал ингэж өөрчлөгдөж байгааг анхааралдаа авч, олон улсын зах зээл дэх үйл ажиллагаагаа бататгахын тулд ХХБ нь одоо явуулж буй олон улсын банкны үйл ажиллагаагаа шинэчлэн, дотоод болон гадаад зах зээлд шинэ бизнес бий болгох зорилготойгоор эрчимтэй ажиллаж байна.

ХХБ нь Монгол улсын экспорт импортын санхүүжилтэд эзэлдэг өөрийн тэргүүлэх байр сууриа бэхжүүлсээр байгаа билээ. Тайлант онд Монгол улсын импортын аккредитивын ихэнх хувийг гаргасан бөгөөд Монгол улсын гадаад валютын арилжааны зах зээл дээр тэргүүлсэн хэвээр байна. Эдгээр үйл ажиллагаанаас гадна олон улсын зах зээлд үнэт цаас гаргасан нь ХХБ Монгол улсыг гадаадад таниулсан санхүүгийн байгууллага гэдгийг дахин нотолж өглөө. Олон улсын үйл ажиллагаагаа дэмжих зорилгоор банк нь гадаадын томоохон банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилласаар байна. HSBC, American Express Bank, ING Bank, Commerzbank Bank, Korean Exchange Bank, Agricultural Bank of China, China Construction Bank, Bank of Tokyo-Mitsubishi UFJ, Mizuho Bank зэрэг банкуудад өөрийн дансдыг байршуулдаг бөгөөд дэлхийн томоохон нэр хүнд бүхий 80 гаруй банк, санхүүгийн байгууллагуудтай корреспондент харилцаатай ажилладаг. Ингэснээрээ банк олон улс дах нэр хүндээ нэмэгдүүлж, өргөн хүрээний санхүүжилтийг олгосоор байна. ХХБ нь Олон улсын санхүүгийн корпорацийн Дэлхийн нийтийн худалдааг дэмжих хөтөлбөрт хамрагдсан Монголын анхны банк болж байсан бөгөөд Өмнөд Солонгос, Тайваний EXIM банкуудаас дахин санхүүжүүлэлтийн хөтөлбөрт оролцсоноор энэ амжилтаа өргөжүүлсэн юм. Нэмж хэлэхэд БНХАУ, Монгол улсын худалдааны үйл ажиллагааг санхүүжүүлэхэд туслах зорилгоор БНХАУ-ын Экспорт болон зээлийн даатгалын корпораци SINOSURE 27

сая ам.долларын зээлийн шугамыг ХХБ-нд нээж өгсөн. Түүнчлэн, манай банк Ази, Европ, Хойд Америкийн томоохон банкуудаас нээх худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын хэмжээг нэмэгдүүлсээр байна. Эдгээр гадаадын томоохон нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагуудын ХХБ-нд зориулан нээсэн худалдааны санхүүжилтийн нийт зээлийн шугамын хэмжээ тайлант онд 15 хувиар нэмэгдэж, 101 сая орчим ам.долларт хүрсэн нь банкны зүгээс харилцагч нартаа бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж худалдан авахад нь үзүүлэх хамгийн таатай санхүүгийн багц үйлчилгээг бий болгоход тусалцаа үзүүлж байна.

Эдийн засгийн өсөлтийг дагаад бизнесийн шинэ боломжууд бий болохын хирээр санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгцээнүүд гарч байна. ХХБ нь Монголын компаниудад дотоодын болон гадаадын хөрөнгийн зах зээлээс санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд нь туслах зорилгоор Хөрөнгө оруулалтын банкны газрыг байгуулж, өөрийн үйлчилгээгээ дахин нэг түвшингээр ахиулаа. Монголын арилжааны банкуудын дунд эзэлсэн баттай байр суурь, итгэлийн үр дүнд бий болсон харилцаандаа үндэслэн манай банк харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагаа, үнэ цэнийг өсгөн нэмэгдүүлэх шинэ шийдлийг санал болгохоор ажилладаг билээ. Үүнд хамтын санхүүжилт, үл хөдлөх эд хөрөнгийн санхүүжилт зэргийг дурьдаж болох юм. Түүнчлэн, ХХБ нь үнэт цаас, итгэлцлийн үйлчилгээ зэрэг санхүүгийн бүрэн цогц үйлчилгээг үзүүлж байна.

Техник технологи үсрэнгүй хөгжихийн хирээр төлбөр гүйцэтгэх, бэлэн мөнгөний гүйлгээ болон бусад үйлчилгээнд өрсөлдөөний шинэ хэлбэр, шийдвэрлэх асуудал болон боломжууд үүсэн бий болж байна. Банк нь Fly Card, Юнител компанитай хамтарсан Мессеж банкны үйлчилгээ гэх мэт хэд хэдэн шинэ бүтээгдэхүүнийг Монголын санхүүгийн зах зээлд нэвтрүүлээ. Картын бүтээгдэхүүн үйлчилгээг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх замаар энэ салбар дахь тэргүүлэх байр сууриа хадгалсаар байна. Нэмүү өртөгтэй санхүүгийн үйлчилгээг хурдацтай өсөж буй картын харилцагчдад үзүүлэх зорилгоор Лоялти картын хөтөлбөрийг өргөжүүлэв. ХХБ нь American Express, Visa, MasterCard, JCB зэрэг дэлхийн санхүүгийн тэргүүлэгч байгууллагуудын бүх төрлийн картуудыг төлбөрт хүлээн авч үйлчилдэг Монгол дахь цорын ганц банк юм.

2007 онд гялалзсан амжилт гаргасан хамтран зүтгэгч захирлууддаа гүнээ талархаж байна. Бид өнгөрсөн жилийн бэрхшээлийг давж, хэзээ хэзээнээс илүү нэгдэн ажиллаж чадсан бөгөөд дараа дараагийн жилүүдэд манай банкны байр суурь ямар байхыг сайтар мэдэрч байна.

Төгсгөлд нь ХХБ-ны нийт хамт олны өмнөөс эрхэм хүндэт харилцагчид, хамтран ажиллагсад та бүхний зогсолтгүй дэмжлэг, хамтын ажиллагаанд тань гүн талархал илэрхийлье. Та бүхнийхээ дэмжлэг, тусалцаатайгаар ХХБ нь Монгол улсын хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулна гэдэгтээ итгэлтэй байна.

▶▶ Анх удаа олон улсын санхүүгийн зах зээлээс харьцангуй урт хугацааны гадаад эх үүсвэрийг татаж чадсан нь үндсэний банкны үйл ажиллагааг олон улсад таниулж, хүлээн зөвшөөрүүлж чадсан төдийгүй, монголын дараа дараагийн банкууд, аж ахуйн нэгжүүдийн олон улсын зах зээл дээр гарах боломжийг нээж өгсөн чухал үйл явдал байлаа. ◀◀

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БАЛБАРЫН МЭДРЭЭ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Худалдаа, хөгжлийн банкны хувь нийлүүлэгчид, харилцагч Та бүхнийхээ амар амгаланг айлтгахын зэрэгцээ Та бүхэндээ 2007 оны ажлын тайлангаа толилууж байна.

Тайлангийн хугацаанд ХХБ нь гадаадын хөрөнгө оруулагчдын өмчлөлөөс үндсэний хөрөнгө оруулагчийн өмчлөлд шилжсэн жил байсан бөгөөд томоохон өөрчлөлт орсон энэ жилд манай банкны хамт олон илүү их хүчин чармайлт гарган ажилласнаар бид хөгжлийнхээ нэгэн хуудсанд амжилт бүтээлийн арвин түүхийг бичиж үлдээлээ.

Бидний ололт амжилтын нэг хүчин зүйл бол энэ хугацаанд бидэнд итгэл найдвар хүлээлгэж, хамтран ажиллаж байгаа харилцагч Та бүхний дэмжлэг тул харилцагч, бизнесийн түншүүддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Худалдаа, хөгжлийн банк 2007 онд нийт активынхаа хэмжээг Монгол улсад анх удаа хагас триллион төгрөгт хүргэж, арилжааны банкуудын нийт зах зээлийн 20 хувийг эзлэх болсноор нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг хамгийн өндөр түвшинд байлгах боломжийг бүрдүүлж, тус улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болж буй тэргүүлэх том харилцагчдыг санхүүгийн хувьд дэмжих бодлогыг амжилттай хэрэгжүүлж байна.

Худалдаа, хөгжлийн банкны үйл ажиллагаанд олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний агентлаг Moody's Investors Service дүн шинжилгээ хийснийг Та бүгд мэднэ. Энэхүү үнэлгээндээ түшиглээд тус банк 2007 онд Олон улсын санхүүгийн зах зээл дээр бонд гаргах хөтөлбөрийг Монгол улсын аж ахуйн нэгжүүдээс анх удаа хэрэгжүүлж, эхний 75 сая ам.долларын бондыг амжилттай борлуулаа. Анх удаа олон улсын санхүүгийн зах зээлээс харьцангуй урт хугацааны гадаад эх үүсвэрийг татаж чадсан нь үндсэний банкны үйл ажиллагааг олон улсад таниулж, хүлээн зөвшөөрүүлж чадсан төдийгүй, монголын дараа дараагийн банкууд, аж ахуйн нэгжүүдийн олон улсын зах зээл дээр гарах боломжийг нээж өгсөн чухал үйл явдал байлаа.

2007 онд банкны үйл ажиллагааг эрчимжүүлж, боловсронгуй болгох зорилгоор бүтцийн өөрчлөлт хийж, банкны зардлын бүтцийг хянаж, түүнийг оновчтойгоор төлөвлөх зэрэг арга хэмжээ авч ажилласны үр дүнд тус банкны үйл ажиллагааны өгөөж, чадавхи дээшилж, эдийн засгийн гол үзүүлэлт болох бүтээмж эрс нэмэгдлээ.

Өнөөдрийн байдлаар, ХХБ нь олон улсын түвшин, шаардлагад бүрэн нийцэх банк санхүүгийн 60 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг 600 гаруй мэргэжлийн шилдэг боловсон хүчин, орчин үеийн техник технологиороо дамжуулан хүргэж байна.

Банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байгаа нэгэн хүчин зүйл бол мэдээллийн технологийн сүүлийн үеийн дэвшлүүдийг байнга ашиглаж байдагт оршиж байгаа бөгөөд 2007 онд бид банкинд ашиглагдаж байсан бүртгэлийн программыг шинэчилж, орчин үеийн банкны нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шаардлагыг хангасан шинэ программд шилжлээ.

Харилцагч, үйлчлүүлэгчидтэй тогтоосон, ажил хэрэгч хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх, тэдний эрэлт хэрэгцээг мэдэрч, түүнд нь нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн бий болгох, хамтын зээлжүүлэлт, худалдааны санхүүжилт, төслийн санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, банкны салбарын тоог нэмэгдүүлэх замаар өнгөрсөн хугацаанд олсон амжилтаа улам батжуулах, илүү их зүйлийг харилцагч нарынхаа төлөө хийх зорилтыг бид цаашдаа тавьж байна.

Энэ бүхнийг банкны чадварлаг ажилтнууд, удирдлагын багийн идэвхтэй үйл ажиллагаа, харилцагч, хамтрагч нарынхаа дэмжлэгтэйгээр ирж байгаа 2008 онд хэрэгжүүлж чадна гэдэгтэй итгэлтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Дарга

Д.Эрдэнэбилэг

Гишүүд:

Д.Мөнхбаатар

Ч.Энхболд

Т.Болдхүү

Т.Цолмон

УДИРДЛАГЫН ХОРОО

Рандолф Коппа

Ерөнхийлөгч

Б.Мэдрээ

Гүйцэтгэх захирал

О.Орхон

Гүйцэтгэх захирлын

тэргүүн орлогч

Д.Гантөгс


Гүйцэтгэх захирлын орлогч

Д.Хүрэлбаатар

Гүйцэтгэх захирлын орлогч

2007 ОНЫ ОЛОЛТ АМЖИЛТУУД

- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас (МҮХАҮТ), МУ-ын Засгийн газар хамтран МУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлэн Худалдаа, хөгжлийн банкныг “ТОП-5 БАНК”-ны тэргүүний банкаар шалгаруулсан;
- МҮХАҮТ-аас жил болгон уламжлал болон зохион байгуулдаг “SILK ROAD AWARD”-аас “Монгол улсын санхүүгийн зах зээлд хамгийн үнэ цэнэтэй хувь нэмэр оруулагч хүн”-ээр Худалдаа, хөгжлийн банкны Ерөнхийлөгч ноён Рандолф Коппаг шалгаруулжээ;
- VISA INTERNATIONAL жилийн туршид хамгийн их гүйлгээ хийсэн, чанартай үйлчилгээ үзүүлсэн зэрэг үзүүлэлтүүдийг үнэлэн “2007 Visa Outstanding Debit Card Issuer” цомоор шагнасан;
- MASTERCARD WORLDWIDE Монголын зах зээл дээр MasterCard картыг төлбөрт хүлээн авч бизнест хамгийн их өсөлтийг гаргасныг өндрөөр үнэлэн “Best Acquiring Business Growth of the Year/ Mongolia” цомоор шагнасан;
- Монголбанк “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол тэмдгээр Н. Нямсүрэн, “Хүндэт жуух”-аар Д. Отгонбилэг, Ж. Цогтбаяр нарыг шагнасан;
- Монголын банкны холбоо 2007 оны банкны салбарын “Шилдэг теллер”-ээр Я. Чулуунцэцэг, “Шилдэг менежер”-ээр Ч. Буянжаргал, “Шилдэг зээлийн эдийн засагч”-аар П. Баатарчулуун, “Шилдэг дилер”-ээр Т. Даваажав нарыг шалгаруулсан;
- Улсын татварын ерөнхий газар, ХХБ Монгол улсын төсөвт 5 тэрбум гаруй төгрөгийн татвар төлснийг үнэлэн “Шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгж”-ээр шалгаруулсан;
- МҮХАҮТ-аас “Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч шилдэг аж ахуйн нэгж”-ээр тодруулсан.



Хувь нийлүүлэгчдийн хурал

Хангалтын зөвлөл

ТҮЗ

Ерөнхийлөгч

Гүйцэтгэх захирал

Актив пассын хяруу

Эрсдэлийн удирдлагын газар

Гаргаад харилцаа, хөрөнгө оруулалтын банкны газар

Дотоод аудитын газар

Удирдлагын хяруу

Гүйцэтгэх захирлын орлогч

Зээлийн хяруу

Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

Хангаалалт, аюулгүй байдлын газар

Байгууллагын банкны газар

Жижиг, дунд байгууллагын банкны газар

Сэнхүүгийн бүртгэл, хангалтын газар

Хуулийн хэлтэс

Хөрөнгө зохицуулалтын газар

Харилцаачийн үйлчилгээний хэлтэс

Хуулийн үйлчилгээний хэлтэс

Мэдээллийн технологийн хэлтэс

Иргэдийн банкны газар

Картын үйлчилгээний төв

Хувийн банкны төв

Хүний нөөцийн газар

Тусгай активын хэлтэс

Төлбөр тооцооны арын албаны хэлтэс

Хөрөнгө зохицуулалт арилжааны арын албаны хэлтэс

Салбар банкны хэлтэс

Салбарууд

Зээлийн хэрэг бүртгэлийн хэлтэс

Касс, үнэт зүйлсийн хэлтэс

Аж ахуйн хэлтэс



Дамбийжавын ХҮРЭЛБААТАР
Гүйцэтгэх захирлын орлогч



Ононгийн ОРХОН
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч



Дамдингийн ГАНТӨГС
Гүйцэтгэх захирлын орлогч



Гомбосүрэнгийн ОСӨХБАЯР
Жижиг, лунд байгууллагын
банкны газрын захирал



Баярбаатарын БАЯРМАА
Иргэдийн банкны газрын
захирал



Найдансүрэнгийн ЗОЛЖАРГАА
Галаад харилцаа,
хоронго оруулалтын банкны
газрын захирал



Навааншаравын НИЯМСҮРЭН
Байгууллагын банкны газрын
захирал



Аниагийн МӨНХБАЯСГАЛАН

Маркетинг, бүтээгдэхүүн хөгжлийн газрын захирал

Дэмчигжавын ОТГОНБИЛЭГ

Дотоод аудитын газрын захирал

Дагмидын ЯНЖМАА

Санхүүгийн бүртгэл, хяналтын газрын захирал

Лувсангийн НИЯМСҮРЭН

Хүний нөөцийн газрын захирал

Загдрагчаагийн ЭРДЭНЭЦАЦРАЛ

Эрсдэлийн удирлалын газрын захирал



Ичинноровын ОРХОНХҮҮ

Мэдээллийн технологийн хэлтсийн захирал

Ванчигсүрэнгийн ЭНХЦЭЦЭГ

Салбар банкны хэлтсийн захирал

Шаравсамбуугийн ЭНХТӨР

Хуулийн хэлтсийн захирал

Баасандоржийн БАТЗАЯА

Хамгаалалт, аюулгүй байдлын газрын захирал

БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТУХАЙ

Монголбанкны мэдээгээр мөнгөний нийлүүлэлт (M2) 2007 оны 12 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 2 401.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2007 оны 11 дүгээр сарынхаас 7.4 хувь буюу 166.1 тэрбум төгрөгөөр, 2006 онтой харьцуулахад 56.3 хувь буюу 864.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2007 оны 12 дугаар сарын эцэст 364.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2006 онтой харьцуулахад 48.5 хувь буюу 119.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн, иргэд, байгууллагын төгрөгийн хугацаат хадгаламж 2006 онтой харьцуулахад 60.8 буюу 421.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, 1 113.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гадаад валютын хадгаламж 376.0 тэрбум төгрөгт хүрсэн нь 2006 онтой харьцуулахад 24.1 хувь буюу 73.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкны салбарын хэмжээгээр активын эргэн төлөгдөх дундаж хугацаа 299 өдөр, пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаа 124 өдөр байна. Тайлант улирлын эцэст банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа хамгийн өндөр нь 163 хувь, бага нь 9.9 хувьтай байна.

Монголбанкнаас баталсан журмын дагуу арилжааны банк нь гадаад валютын нээлттэй позицийг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицгийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай байдаг. Банкны салбарын дундаж үзүүлэлтээр 2007 онд нийт нээлттэй позицгийн зохистой харьцаа нь өмнөх оноос 0.6 нэгжээр буурч 30.1 хувь хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон хязгаарт байна.

Банкны салбар тогтвортой хөгжиж, үйл ажиллагаа нь өргөжиж байна. 2007 онд Нийт актив /ДНБ-ий харьцаа 74.2 хувь, Зээл/ ДНБ-ий харьцаа 45.1 хувь, Хадгаламж/ДНБ-ий харьцаа 32.1 хувь, Харилцах/ДНБ-ий харьцаа 13.6 хувьтай тус тус байгаа нь 2006 оноос өссөн хандлагатай байна. Банкны үйлчилгээний төрөл олширч зах зээлд нэвтэрсээр байгаагийн нэг жишээ нь орон сууцны ипотекийн зээлийн үйлчилгээ болж байна. Банкуудын олгосон ийм зээлийн хэмжээ 2007 онд 68.4 тэрбум төгрөгөөс 143 гаруй тэрбум төгрөг болтлоо өсчээ.

Тайлант улирлын байдлаар банкуудын нийт активын 60.0 хувийг дотоодын цэвэр зээл, 12.5 хувийг гадаад актив, 7.5 хувийг бусад банкнаас авах авлага, 7.4 хувийг банкны нөөц, үлдсэн 12.6 хувийг бусад актив тус тус бүрдүүлж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийг 2006 онтой харьцуулахад 68.1, хувиар өсч, 2 056.1 тэрбум төгрөгт хүрснээс хэвийн зээлийн өрийн үлдэгдэл дотор хувийн секторынх 83.3 хувь, иргэдийнх 67.8 хувь, бусад секторынх 32.0


хувь, бусад санхүүгийн байгууллагынх 56.6 хувь тус тус өсч, улсын секторынх 28.5 хувиар буурсан байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 21.0 хувь, чанаргүй зээл 13.4 хувь өссөн байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 68.1 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.3 хувийг эзэлж байна.

Банкны активд эзлэх зээлийн хувийн жин сүүлийн 4-5 жилд 48-54 хувийн түвшинд хэлбэлзэж байна. Энэ нь Монголбанкнаас баримталж буй зээлийн хэмжээг активын 50 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого, банкууд зээлийн эрсдэлээс болгоомжилж, эрсдэл багатай активд хөрөнгөө байршуулах сонирхолтой зэргээс шалтгаалж байна.




2007 оны эцсийн байдлаар банкны салбарт 16 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. 2006 онтой харьцуулахад ХХБ-ны нийт актив 32.2 хувь буюу 137.2 тэрбум төгрөгөөр өсч, 563.5 тэрбум төгрөгт хүрсэн нь банкуудын нийт активын 17.4 хувийг эзэлж байна. Нийт зээл өмнөх оны эцэстэй харьцуулахад 54.6 хувь буюу 147.2 тэрбум төгрөгөөр өсч, 387.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкуудын нийт зээлийн 17.2 хувийг эзэлж байна.

Нийт актив (зах зээлд эзлэх хувиар)



Нийт зээл (зах зээлд эзлэх хувиар)



ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

▶▶ Монгол улсын банк санхүүгийн салбарт 500 тэрбум төгрөгийн активтай анхны банк боллоо. ◀◀


- Монгол улсын банк санхүүгийн салбарт 500 тэрбум төгрөгийн активтай анхны банк боллоо.
- 2007 оны 1-р сард ING банктай хамтран олон улсын санхүүгийн зах зээлд бонд гаргах Европын дунд хугацааны үнэт цаасны 150 сая ам.долларын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс эхний хэсэг болох 2010 онд эргэн төлөгдөх 75 сая ам.долларын бондыг амжилттай борлууллаа.
- Монгол улсын компани, аж ахуйн нэгжүүдэд олон улсын болон дотоодын зах зээлээс хөрөнгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд нь туслах зорилгоор Хөрөнгө оруулалтын банкны газрыг шинээр байгууллаа.
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлсний үндсэн дээр Mizuho Corporate Bank, Commerzbank, Bank Austria Creditanstalt, Vneshtorgbank зэрэг банкууд ХХБ-нд зээлийн шугамыг тус тус нээж өгсөн.
- 2007 оны 6 дугаар сард Германы Bayern LB банктай хамтын ажиллагааны Ерөнхий гэрээнд гарын үсэг зурснаар харилцагчдынхаа урт хугацааны худалдааны болон төрөл бүрийн зээлийг санхүүжүүлэх бололцоогоо нэмэгдүүлсэн.
- Харилцагч нарынхаа Герман болон Европын бусад улс орнуудаас төрөл бүрийн бараа бүтээгдэхүүний импортлох үйл ажиллагаанд зориулж урт хугацааны худалдааны санхүүжилтийн хүрээнд нээгдсэн аккредитивыг Германы BHF банкны зээлээр санхүүжүүлэхээр Европын Экспорт кредитын агентлагуудтай хамтран ерөнхий гэрээнд гарын үсэг зурлаа.
- Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Хувийн хэвшлийг дэмжих төслийн зээл 2”-ийн хүрээнд өөрийн харилцагч нар болох жижиг, дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны төслүүдийг санхүүжүүлээд байна.
- Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас хэрэгжүүлж буй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шатлалт төсөл”-д дамжуулан зээлдүүлэгч банкаар сонгогдон оролцох гэрээний асуудлыг эцэслэн шийдвэрлүүлсэн.
- “Мессеж банк”-ны үйлчилгээг Мобиком, Скайтел компаниудтай хамтран хэрэгжүүлж байсныг өргөжүүлж, Юнител компанитай хамтран зах зээлд нэвтрүүлээ.
- Орон зай, цаг хугацаанаас үл хамааран урьдчилсан төлбөрт ярианы нэгжийг гар утсаараа дамжуулан худалдан авах боломж бүхий Fly Card үйлчилгээг Скайтел компанитай хамтран хэрэгжүүлж харилцагч нартаа бэлэг барилаа.
- Банкны онлайн холболтыг шинэчилж, JCB, MasterCard картуудыг онлайн хэлбэрээр төлбөрт хүлээн авах боломжтой болсон.
- VISA INTERNATIONAL-ийн зүгээс VISA EMI картыг төлбөрт хүлээн авахыг зөвшөөрсөн Монгол улс дахь анхны банк боллоо.
- Өөрийн нэрийн олон улсын Мастер картыг шинээр зах зээлд гаргалаа.
- Харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ ажлын байр худалдан авах, түрээслэх хэрэгцээг хангах зорилгоор “Урт хугацаат үл хөдлөх эд хөрөнгийн зээл”-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр гаргалаа.
- Том харилцагч нартаа зориулан шинээр Овердрафтын үйлчилгээг гаргасан нь тэдгээрийн богино хугацааны санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд нэн оновчтой санхүүгийн шийдэл боллоо.
- Харилцагч, үйлчлүүлэгчиддээ банкны үйлчилгээг илүү ойртуулах зорилгоор Чингэлтэй салбарыг шинээр нээлээ.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


►► Тайлант онд банкны нийт активын хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 32.1 хувиар өсч, 563.2 тэрбум төгрөгт, татварын дараах цэвэр ашиг 39.3 хувиар өсч, 16.4 тэрбум төгрөгт хүрсэн нь дундаж өөрийн хөрөнгийн өгөөжийг 29.8 хувьд хүргэж чадлаа. ◀◀

Орлого зарлагын хураангуй	2006 он	Сая төг 2007 он
Хүүгийн орлого	36.037	47.322
Цэвэр хүүний орлого	21.448	20.647
Үйл ажиллагааны орлого	30.310	31.073
Цэвэр ашиг	11.774	16.396
Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд		
Өөрийн хөрөнгийн өгөөж	23.7%	23.9%
Активын өгөөж	2.8%	2.9%
Хураангуй тэнцэл		
Актив хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө, банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	134.943	110.375
Зээл, үнэт цаас, урьдчилгаа	240.106	382.308
Бусад	51.243	70.819
Нийт актив	426.292	563.503
Пассив хөрөнгө		
Харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	324.669	373.018
Банк болон санхүүгийн байгууллагуудын хөрөнгө	36.041	22.649
Бусад пассив	6.562	98.205
Хоёрдогч өглөг	9.320	9.359
Нийт пассив	376.592	503.233
Өөрийн хөрөнгө	49.700	60.270
Нийт пассив болон өөрийн хөрөнгө	426.292	563.503
Зохистой харьцааны үзүүлэлтүүд		
Өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын харьцаа (>10%)	18.5%	13.7%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа (<18%)	27.5%	26.0%
Гадаад валютын ханшийн эрсдэл (<10%)	1.5%	0.6%
Зээл төвлөрлийн эрсдэлийн харьцаа (<20%)	14.8%	18.0%
Холбогдох этгээдийн зээлийн төвлөрлийн эрсдэлийн харьцаа (<5%)	0.1%	0.1%


Өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын харьцаа




Нийт олгосон зээл/Найдваргүй зээл




2006 оны орлого



2007 оны орлого





2006 оны зардал



2007 оны зардал





Байгууллагын банкны газар


ББГ нь өөрийн төвлөрөн ажилладаг зах зээл, гол харилцагчид болох Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын том аж ахуйн нэгжүүдийн хүсэн хүлээж буй санхүүгийн үйлчилгээнүүдийг бүрэн төгс, чанарын өндөр түвшинд үргэлжлүүлэн хүргэдэг.

- Үйл ажиллагаа
- Бизнесийн зээл
- Аккредитив
- Санхүүгийн
- Баталгаа
- Үл хөдлөх хөрөнгийн зээл



Жижиг, дунд байгууллагын банкны газар

ЖДБ-ийн санхүүжилтийг зөвхөн өөрийн дотоод эх үүсвэрээр төдийгүй, олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлж, жижиг, дунд бизнесийг дэмжин ажилладаг.



Үйл ажиллагаа

Эргэлтийн хөрөнгийн зээл
Урт хугацаат үл хөдлөх
Хөрөнгийн зээл
Импортыг дэмжих зээл
Төслийн зээл



Иргэдийн банкны газар

Иргэдийн банк нь иргэдэд зориулсан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч нартаа түргэн шуурхай найдвартай хүргэдэг.

Үйл ажиллагаа

Хувийн харилцаа
Хадгаламж
Хадгаламжийн хайрцаг
Карт
Чекийн үйлчилгээ
Зээл
Мөнгөн гуйвуулга





БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

▶▶ Олон улсын санхүүгийн зах зээлээс хямд эх үүсвэр татан төвлөрүүлснээр бага хүүтэй урт хугацааны зээлийг Монгол улсын томоохон аж ахуйн нэгжүүдэд санал болгож чадлаа. ◀◀


Тайлант 2007 оны хувьд ХХБ-ны ББГ нь өөрийн төвлөрөн ажилладаг зах зээл, гол харилцагчид болох Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын том аж ахуйн нэгжүүдийн хүсэн хүлээж буй санхүүгийн үйлчилгээнүүдийг бүрэн төгс, чанарын өндөр түвшинд үргэлжлүүлэн хүргэх, эдгээр үйлчилгээнүүдээс олох орлогынхоо хэмжээг 30-аас багагүй хувиар өсгөх, зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах, гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх зорилтуудыг тавьж ажиллалаа.

Тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэх үүднээс газрын дотоодод бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Энэхүү өөрчлөлтийн дагуу тайлант оны

2 дугаар сараас эхлэн борлуулалт, шинжилгээ, хяналтын гэсэн гурван хэсэгт хуваагдан ажилласан бөгөөд бүтэц зохион байгуулалт нь харилцагч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг улам гүн гүнзгий танин мэдэх, зээл хүссэн өргөдлүүдийг хурдан шуурхай шийдвэрлэх, нэг харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, зээл олголт, төлөлтийн хяналтыг сайжруулах зэрэг тулгамдсан асуудлуудыг үр бүтээлтэй шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн алхам боллоо.

Оновчтой төлөвлөсөн зорилго зорилтууд, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дүнд ББГ-ын үйл ажиллагааны бүтээмж нэмэгдэж, зээлийн багцын дүнг 2006 оны 12-р сарын 31-ний өдрийн зээлийн багцын дүнтэй харьцуулахад 124.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант оны эцэст газрын зээлийн багц 278.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зээлийн багцын өсөлтийг он дарааллаар харуулбал:


Байгууллагын банкны газрын зээлийн багцын өсөлт (Тэрбум төгрөгөөр)



Монгол улсын эдийн засаг өсөн нэмэгдэхийн хирээр харилцагч үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээг улам гүнзгий мэдрэх шаардлагатай болж, зах зээлийн хөгжилтэй хөл нийлүүлэх зорилтын хүрээнд үл хөдлөх хөрөнгийн зээл, овердрафтын үйлчилгээ гэсэн шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэв.

Үл хөдлөх эд хөрөнгийн зээл нь Монгол улсын банк санхүүгийн салбарт бизнесийн зориулалттай урт хугацаат үл хөдлөх хөрөнгийн анхдагч бүтээгдэхүүн болсон бөгөөд жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжихэд үлэмж хувь нэмрийг оруулж байна.

Банкны зээлийн багцын бүтэц. Эдийн засгийн салбаруудаар



Овердрафтын үйлчилгээ нь тус газрын харилцагчдын богино хугацааны санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд нэн оновчтой санхүүгийн үйлчилгээ болж чадсан бөгөөд оны эцсийн байдлаар нийт 2 тэрбум орчим төгрөгийн зээл олголт хийгдээд байна.

ББГ нь харилцагч болон харилцагч бус аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулан банкны цогц бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулгыг тогтмол хүргүүлж байна.

Зээлийн багцын чанарыг сайжруулах, эрсдэлийг бууруулах үүднээс “Том болон жижиг дунд байгууллагад олгох зээлийн заавар”, алт олборлолт, мах бэлтгэл болон боловсруулах, барилгын салбарын зээлийн бодлогыг ЭУГ, ХХ, ЗХБХ зэрэг газруудтай хамтран шинэчлэн боловсруулав. Зах зээлийн өрсөлдөөн, харилцагчийн эрэлт хүсэлтийг судалсны үндсэн дээр “Аккредитив, баталгаа, батлан даалтын хүү шимтгэлийн нөхцөл”-д өөрчлөлт орууллаа. Эдгээр нь зээлийн хүсэлтийг шийдвэрлэх хугацааг шуурхай болгох, зөвхөн банкны төдийгүй харилцагчийг бизнесийн болон бусад эрсдэлээс хамгаалах, харилцагчдын хэрэгцээнд тохирсон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, тэдний санхүүгийн зардлыг бууруулах зэрэг ач холбогдолтой болсон.

Тайлант оны өмнөх жилүүдэд ХХБ нь өөрийн олгох зээлийн хязгаараас давсан төслүүдийг гадаад улсын банкуудтай хамтран санхүүжүүлж байсан бол 2007 оны хувьд дотоодын банкуудтай хамтрах бодлого барьж ажилласан.

Улмаар зээлийн хүүгийн болон аккредитив, баталгааны шимтгэлийн орлого нь ББГ-ын орлогод шууд нөлөөлж, тайлант онд хүү шимтгэлийн орлого өмнөх оныхоос 32 хувиар өсч, нийт 26.3 тэрбум төгрөгт хүрлээ. Хүү шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрээр харуулбал:

	2006 он	2007 он	2006/2007 өсөлт
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	
НИЙТ ДҮН	19,915.1	26,290.3	32%
Хүүгийн орлого	19,045.5	23,791.3	24.9%
Аккредитив	693.3	1,182.2	70.5%
Баталгаа	176.3	307.2	74.3%



ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ


▶▶ 75 сая ам. долларын бондыг амжилттай арилжаалснаар иргэдэд олгох орон сууцны зээлийн хүү сарын 1,3 % болж, зах зээлийн хамгийн таатай нөхцлийг бүрдүүлсэн тул тайлант онд өмнөх онтой харьцуулахад орон сууцны зээлийн багц 8,2 тэрбум төгрөгөөр өсжээ.

ХХБ-ны ИБГ нь тайлант 2007 онд иргэдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг өргөжүүлэхэд улам бүр анхааран, арилжааны зээл олголтыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх сувгуудыг олшруулж, улмаар техник, технологийн дэвшилтэт арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн ажиллалаа.

Тайлант оны амжилттай үйл ажиллагаа, ололт дэвшлүүд нь цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ хүү шимтгэлийн нөхцлүүдийг бууруулан ажиллах нөхцлийг бүрдүүлэв.

Зээлийн үйлчилгээ

Иргэдэд зориулсан зээлийн өрийн үлдэгдэл тайлант оны эцэст 62.6 тэрбум төгрөг байсан нь банкны нийт зээлийн багцын 16.1%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оны эцсээс 57%-иар өссөн үзүүлэлт юм. Иргэдэд зориулсан зээлийн өрийн үлдэгдлийн өсөлтийг харуулбал:



Зээлийн багцын хэмжээ өссөнөөр тус газрын хүүний орлого 2006 онтой харьцуулахад 17.9% хувиар өсч, 10 тэрбум төгрөгт хүрлээ.

Улмаар тус банкны орон сууцны зээл нь харилцагч үйлчлүүлэгчдэд банк санхүүгийн зах зээл дэх хамгийн таатай нөхцөлтэй бүтээгдэхүүн байсан тул тайлант онд өмнөх онтой харьцуулахад 8,2 тэрбум төгрөгөөр өсч, нийт иргэдийн зээлийн багцад эзлэх хувь 16-гаас 26 болж өссөн байна.

Иргэдэд зориулсан зээлийн багцын бүтэц




Түүнчлэн, тайлант онд тус газар нь бизнесийн зээл, орон сууцны зээл, цалингийн зээл зэрэг бүтээгдэхүүнүүдийнхээ нөхцлийг илүү таатай болгож, сарын хүүг 0.4-0.8 хувиар бууруулсны дээр иргэдэд зориулсан “Үл хөдлөх эд хөрөнгийн зээл”, “Тэтгэвэр барьцаалсан зээл” зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд шинээр гаргалаа.

Хадгаламж

Тайлант онд иргэдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 32,9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 156,4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 26.7 хувиар өссөн байна.

Хадгаламжийн өсөлтийг сүүлийн жилүүдээр харуулбал:



Хадгаламжийн үйлчилгээг төгрөг, ам.доллар, евро зэрэг валютуудаар хүргэж байсныг нэмэгдүүлж, юанийн хадгаламжийн үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Ингэснээр тус банк нь Монгол улсын банкны системд хамгийн олон төрлийн валютаар хадгаламжийн үйлчилгээ үзүүлдэг банк болоод байна.

Мөнгөн гуйвуулга, чекийн үйлчилгээ

Тус банк нь олон улсын мөнгөн гуйвуулгын MoneyGram үйлчилгээг Монголшудан, Капитрон, Анод, Эрэл, Хадгаламж, Улаанбаатар хотын банк зэрэг агент банкуудтай хамтарсан сүлжээгээр дамжуулан Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн иргэдэд үзүүлдэг.

Тайлант онд энэхүү үйлчилгээний ашиг тусыг сурталчлах, чанарыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дүнд хийгдсэн гуйвуулгын хэмжээ өмнөх оноос 35.8%-иар өсч, 27.7 сая ам.долларт хүрлээ.



Олон улсын банк санхүүгийн чекийн үйлчилгээний цар хүрээнд дэлхийд зөвхөн гурван оронд л American Express Gift Cheque буюу Бэлэглэлийн чек худалдагддаг ба эдгээр

орнуудын нэг нь манай орон юм. ХХБ нь уг чекийг Монголын зах зээлд үйлчилгээндээ нэвтрүүлсэн анхны банк болсноор харилцагч та бэлэг худалдан авах гэж цаг заваа үрэх хэрэггүй болсон.

ХХБ нь Монгол улсын банкны салбарт мессеж банкны үйлчилгээ, интернэт банк, факсаар төлбөр тооцоо хийх үйлчилгээ, цахим нэхэмжлэх, Fly Card, АТМ зэрэг биет бус сувгуудаар хүргэх хамгийн олон төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Энэ бүхэн тус банкны харилцагч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, банкаар үйлчлүүлэх зардлыг нь бууруулан, бүтээгдэхүүн үйлчилгээ авах нөхцлүүдийг хялбар, энгийн болгож байна.

Тайлант 2007 онд ХХБ нь хөдөлгөөнт холбооны оператор болох Skytel компанитай хамтран Fly Card үйлчилгээг шинээр зах зээлд гаргав. Fly Card үйлчилгээ нь гар утаснаасаа мессеж илгээн ярианы урьдчилсан төлбөрт нэгжийг ХХБ-нд байрших өөрийн карт болон харилцах дансан дахь мөнгөн хөрөнгөөрөө орон зай, цаг хугацаанаас үл хамааран худалдан авах үйлчилгээ юм.

Тайлант онд ИБГ-ын харилцагчдын мессеж банкаар үйлчлүүлсэн тоо 2006 оныхоос 7,5 дахин, харилцагчдын тоо нь 3,4 дахин өсч 9900-д хүрсэн байна.

Түүнчлэн, ХХБ нь АТМ-ы үйлчилгээг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн, хамгийн том сүлжээ бүхий банк бөгөөд тайлант онд АТМ-ы тоог нэмэгдүүлснээр уг үйлчилгээг Улаанбаатар хотод 35, хөдөө орон нутагт 9 машинаар дамжуулан хүргэлээ. Мэдээллийн технологийн өндөр хурдацтай хөгжлийн ирээдүй нь үйлчилгээ үзүүлэхэд тав тухтай, хялбар, олон төрлийн боломжтой, хямд зардал бүхий АТМ ойрын ирээдүйд банкны салбаруудыг орлож, 24 цагийн туршид үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох болно гэж үзэж байгаа билээ.

Хувийн банкны үйлчилгээ

ИБГ-ын харьяа Хувийн банкны төв нь хувийн хадгаламж эзэмшигч гадаад, дотоодын иргэд харилцагчиддаа санхүүгийн мэдээллийн нууцлалыг өндөр түвшинд хангасан, тохилог, тав тухтай орчинд банкны бүх төрлийн үйлчилгээг нэг цэгт үзүүлдэг бөгөөд энэ нь банкны харилцагчдын тоо, улмаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд үлэмж хувь нэмрийг оруулж байна.

Тайлант онд Хувийн банкны төвийн харилцагчдын тоо 30% -иар, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 18 % буюу 4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хувийн банкны төв нь өөрийн хадгаламж эзэмшигчиддээ санхүүгийн уян хатан нөхцөл, зээлийн хамгийн өндөр хязгаартай банкны шилдэг бүтээгдэхүүн, нэр төрийн баталгаа болсон Платинум картыг олгодог бөгөөд 2007 онд Платинум карт эзэмшигчдийн тоо урьд оныхоос 42 %-иар өссөн байна.

Картын үйлчилгээ

Тайлант онд ХХБ нь өөрийн картын бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг улам боловсронгуй болгож, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар тухайн зах зээл дэх тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллалаа.

Улмаар 2007 он нь тус банкны картын бизнесийн цаашдын хөгжил, дэвшилд чухал ололт амжилтуудыг авчирсан жил байв. ХХБ нь дэлхийн картын зах зээлд тэргүүлэгч VISA, American Express®, MasterCard®, JCB картуудыг Монгол улсын нутаг дэвсгэр дээр төлбөрт хүлээн авдаг цорын ганц банк хэвээр байгаа бөгөөд тайлант онд зах зээлд гаргасан шинэ карт эзэмшигчдийн тоо 28 000-д хүрснээр нийт карт эзэмшигчдийн тоо 100 000 давлаа. Энэ нь өмнөх 2006 оны эцсээс даруй 38 хувиар нэмэгдсэн өсөлт юм.

Зах зээлд гаргасан картын тоог өсгөхийн зэрэгцээ бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, тайлант оны дундаас эхлэн MasterCard®-ийг онлайн хэлбэрээр төлбөрт хүлээн авдаг болов. Түүнчлэн, гэрээт банкны сүлжээг өргөтгөх зорилгоор дотоодын бусад банкуудтай хамтран ажиллалаа.

ХХБ нь өөрийн харилцагч үйлчлүүлэгчиддээ тав тухтай, найрсаг үйлчилгээ үзүүлэхийг ямагт эрмэлздэг бөгөөд энэхүү зорилтын хүрээнд биет бус сувгийн үйлчилгээнүүдийг дээд зэргийн түвшинд хүргэж, харилцагч үйлчлүүлэгчдэд хялбар болгох зорилгоор онлайн үйлчилгээнүүдийг улам боловсронгуй болгоход нэн анхаарч ажиллалаа. Тухайлбал, Монгол улсын үүрэн телефоны анхдагч оператор болох Мобиком корпорацитай хамтран үүрэн телефоны дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгч нарт зориулсан цахим нэхэмжлэхийн буюу “E-billing”-ийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв. Mobicom Loyalty картын эзэмшигч нарт зориулж, тэдгээрийн Мобикомын үйлчилгээний барьцаа төлбөрийг эзэмшигч бүрийн нэр дээр нээсэн хугацаагүй хадгаламжийн дансанд хуримтлуулах болсон нь харилцагч үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн шийдэл болж чадлаа. Мөн дэлхийд алдартай JCB картыг онлайн хэлбэрээр төлбөрт хүлээн авч үйлчилдэг болсон нь дотоодын зах зээлд хамгийн олон картыг төлбөрт хүлээн авч үйлчилдэг давуу байдлаа бататгаж үлдээхэд ач холбогдолтой алхам болсон юм.

Өнгөрсөн хугацаанд зах зээлд гаргасан, нэмүү өртгийг бий болгогч бүтээгдэхүүнүүд болох интернэт төлбөр тооцоо, урьдчилсан төлбөрт ярианы картыг АТМ-аар худалдах зэрэг үйлчилгээнүүдийн найдвартай ажиллагааг илүү өндөр түвшинд хүргэж сайжрууллаа. Урьдчилсан төлбөрт үйлчилгээний ярианы картын борлуулалтын сувгийг өргөжүүлж, ХХБ-ны харилцагч нар өөрийн картын болоод харилцах данснаасаа гар утсаа ашиглан ярианы нэгж худалдан авах боломжтой болов.

Харилцагч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг судлах, түүнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, тасралтгүй хүргэх зорилгын хүрээнд картын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү шимтгэл, хураамжийн нөхцлийг уян хатан, зах зээлийн хамгийн тааламжтай түвшинд байлгаж ажилласан нь карт эзэмшигчдийн тоо 38 хувиар, картын үйлчилгээний шимтгэлийн орлого 50-иас дээш хувиар өсөн нэмэгдэхэд нөлөөллөө.

Картын үйл ажиллагааны найдвартай байдлыг нэмэгдүүлж, харилцагчдад түргэн шуурхай хүргэх зорилгоор АТМ-ы сүлжээг өндөр хурдны оптик сүлжээнд оруулав. Түүнчлэн, картын систем, сүлжээний байнгын тасралтгүй үйл ажиллагааг дээд зэргийн түвшинд хангаж ажиллаж ирэв.

ХХБ нь санхүүгийн жил бүрийн эхний улиралд харилцагч үйлчилгээний байгууллагуудтай тогтоосон харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа дүгнэж, цаашдын бодлогоо тодорхойлох талаар санал солилцох зорилготой уулзалт зөвлөгөөнийг уламжлал болгон зохион

байгуулдаг бөгөөд 2007 оны зөвлөгөөн нь банк санхүүгийн зах зээл эрчимтэй өсч хөгжин, өрсөлдөөн нэмэгдэж буй өнөө үед харилцагчдын эрэлт, хэрэгцээг тодорхойлж өгсөн үйл ажиллагаа боллоо.



Салбарын удирдлагын хэлтэс

Салбарын удирдлагын хэлтэс нь 2007 оны 7-р сард салбаруудын үйл ажиллагааг сайжруулан жигдрүүлэх зорилгоор байгуулагдсан.

Тайлант онд Салбарын удирдлагын хэлтэс нь салбаруудын тоог нэмэгдүүлж 22 болгох, салбаруудын орлогыг нийт орлогын 24 хувь буюу 13.8 тэрбум төгрөгт хүргэх, шинэ бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллалаа.

Эдгээр зорилтуудын хүрээнд Чингэлтэй салбарыг шинээр нээж, 811-р салбарын үйл ажиллагааг бие даасан хэлбэрт шилжүүллээ. Алтанбулаг тооцооны төв, Замын-Үүд тооцооны төвүүдийг татан буулгаж, бүтцийн өөрчлөлт хийв.

Салбаруудын нийт зээлийн багцын үлдэгдэл 2007 оны эцэст 61.4 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны нийт зээлийн багцын үлдэгдлийн 15.5 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.6 хувиар өссөн байна. Нийт орлого 12.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 10.6 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд банкны нийт орлогын 20.2 хувийг эзэлж байна.

Жижиг бизнес, орон сууцны зээлийн хүүг бууруулсан нь зээлийн багцыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болсноос гадна орон нутгийн зах зээлд тохирсон тэтгэвэр барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлснээр харилцагч нарынхаа сэтгэл ханамжийг дээшлүүллээ.



ГАДААД ХАРИЛЦАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

►► Bayern LB, Wachovia Bank, Mizuho Corporate Bank зэрэг гадаадын томоохон банкуудтай шинээр харилцаа тогтоож, Mizuho Corporate Bank-д Японы иений дансаа байршуулснаар ХХБ-ны гадаадын банкуудад байршдаг ностро дансдын тоо 23, корреспондент харилцаатай банкуудын тоо 80 гаруйд хүрлээ. ◀◀

Гадаад харилцаа

Тайлант онд ГХХОБГ нь Bayern LB, Wachovia Bank, Mizuho Corporate Bank зэрэг гадаадын томоохон банкуудтай шинээр харилцаа тогтоож, Mizuho Corporate Bank-д Японы иений дансаа байршуулснаар ХХБ-ны гадаадын банкуудад байршдаг ностро дансдын тоо 23, корреспондент харилцаатай банкуудын тоо 80 гаруйд хүрлээ.

ХХБ нь 2007 оны 6 дугаар сард Bayern LB-тэй хамтын ажиллагааны ерөнхий гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээгээр банк хоорондын зээл, зээлийн хүү, экспортын кредит агентлаг (ECA)-ийн шимтгэл, төлбөрийн нөхцлүүд зэргийг зохицуулах юм. Мөн BhF банктай “Framework Agreement” байгуулснаар өмнө нь тогтоосон бизнесийн харилцааг өргөжүүлсэн ба ХХБ-ны харилцагчид Европын улс орнуудаас бараа, бүтээгдэхүүн импортоор авахдаа экспортын кредит агентлаг (ECA)-аар даатгуулан урт хугацааны санхүүжилт авах боломжтой болж байгаа юм.

Олон улсын хөрөнгийн зах зээл дээрх үйл ажиллагаагаа өргөжүүлснээр ХХБ нь Man Group-т шинээр үнэт цаасны арилжааны CFD данс нээлээ.

Төслийн зээлүүдийг хэрэгжүүлэх талаар

Дэлхийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны банк /“ЯОУХАБ”/, KfW банкуудаас тус банкаар дамжуулан олгож буй төрөл бүрийн төслийн зээлийн үйл ажиллагаанд дамжуулан зээлдэгч банкны үүрэг гүйцэтгэж, эдгээр олон улсын байгууллагуудтай харилцах харилцаа улам бүр өргөжлөө.

Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Хувийн хэвшлийг дэмжих төслийн зээл 2”-ын хүрээнд ГХХОБГ нь банкны бусад газар, салбар нэгжүүдтэй хамтран ажиллаж өөрийн харилцагч нарын бизнесийг өргөжүүлэхэд туслах зорилгоор нийт 640.0 мянган ам.доллар болон 455 сая төгрөгийн 7 дэд зээлийн эх үүсвэрийн асуудлыг шийдүүлэн зээлдэгчдэд дамжуулан олгоод байна.

Мөн ЯОУХАБ-наас хэрэгжүүлж буй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шатлалт төсөл”-д оролцох гэрээнд гарын үсэг зурж, уг төслийн хэрэгжилтийн хүрээнд 4 дэд зээлийн төслийн саналыг Төслийн удирдлагын хороогоор батлуулаад байна.

Худалдааны санхүүжилт

Тайлант онд Mizuho Corporate Bank, Commerzbank, Bank Austria Creditanstalt, Vneshtorgbank зэрэг банкууд зээлийн шугам баталсан бөгөөд худалдааны санхүүжилтийн нийт зээлийн шугамын хэмжээ 101 сая орчим ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар нэмэгдсэн байна. Эдгээр гадаадын томоохон нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагын зээлийн шугамын хэмжээ нэмэгдэх тусам манай харилцагчид илүү уян хатан хүү шимтгэлийн нөхцөлтэйгээр худалдааны санхүүжилт авах, нээлгэсэн аккредитиваа дамжуулах, баталгаажуулах боломжтой болж бизнесийн үйл ажиллагаа нь өргөжиж байна.

ХХБ нь 2006 онд зээлийн шугамын хэмжээг нэмэгдүүлэх тал дээр түлхүү ажилласан бол тайлант 2007 онд эдгээр шугамын жигд ашиглалтыг сайжруулахад ихээхэн анхаарч ажиллалаа. Үүний үр дүнд урьд дан ганц ING банкаар ихэнх аккредитив баталгаажуулагдаж байсан бол одоогоор банкны хувьд стратегийн чухал ач холбогдол бүхий түншүүд болох RZB, Mizuho Corporate Bank, American Express Bank, BhF зэрэг банкуудын зээлийн

хязгаарын ашиглалт хурдан өсч, бизнесийн харилцаа холбоо улам бүр нэмэгдэж байна. Мөн 2007 онд “Дэлхий нийтийн худалдааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Олон улсын санхүүгийн корпорациас ХХБ-нд олгосон 5 сая ам.долларын аккредитивын баталгааны ашиглалт улам бүр нэмэгдэж харилцагчдын 1 жилээс дээш хугацаагаар нээсэн аккредитивыг баталгаажуулахад амжилттай ашиглагдаж байна.

Цаашдаа ГХХОБГ нь корреспондент банкуудаас олгосон зээлийн шугамын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байгаа бөгөөд ингэснээр зээлийн шугамын хэмжээ, нөхцлийг сайжруулах, харилцагчдын нээсэн аккредитивыг илүү бага хүү шимтгэлтэйгээр тэдгээр олон улсын банк санхүүгийн байгууллагаар баталгаажуулах болон дамжуулах өргөн боломжийг бидэнд олгож байна.

Хамтын санхүүжилтийн зээл

Өнгөрсөн 2007 онд гадаадын нэр хүнд бүхий томоохон банк санхүүгийн байгууллагуудаас зохион байгуулсан хамтын санхүүжүүлэлтэд оролцож, нийт 1,85 тэрбум төгрөгийн хүүгийн болон шимтгэлийн орлого оллоо.

2007 оны жилийн эцсийн байдлаар хамтын санхүүжилтийн хүрээнд бусад банк санхүүгийн байгууллагад олгосон зээлийн өрийн үлдэгдэл 4 сая ам.долларт хүрч байна. Энэхүү хамтын санхүүжилтийн зээлийн өрийн үлдэгдэл, олголт буурсны гол шалтгаан нь олон улсын зах зээл дээрх хамтын санхүүжилтийн маржин буурсан болон дотоодын харилцагчдад олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх ХХБ-ны бодлого зэрэгтэй холбоотой юм.

Дотоодын томоохон харилцагч нартаа зориулан бусад гадаад дотоодын банкуудтай хамтран нийт 21 сая ам.долларын хамтын санхүүжилтийн зээлийг олгов.

Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа

2007 оны 1-р сард ХХБ нь ING банктэй хамтран олон улсын санхүүгийн зах зээлд бонд гаргах Европын дунд хугацааны үнэт цаасны 150 сая ам.долларын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс эхний хэсэг болох 2010 онд эргэн төлөгдөх 8.625 хувийн хүүтэй, 75 сая ам.долларын бондыг амжилттай борлуулсан. Үг бондыг Сингапур (37 хувь), Хонг-Конг (25 хувь), Их Британи (17 хувь), Европын зарим орнууд (16 хувь), АНУ (5 хувь) зэрэг 13 орны 96 хөрөнгө оруулагчид худалдан авсан байна.

Хөрөнгө оруулагчдын бүтэц нь хөрөнгө оруулалтын сангууд (42 хувь), иргэдийн, хувийн жижиглэнгийн болон хувийн банкны байгууллагууд (38 хувь), санхүүгийн байгууллагууд (17 хувь), тэтгэврийн сангууд (3 хувь) зэргээс бүрдэж байна.

Мөн энэ оны сүүлийн хагас жилд тус банк нь олон улсын хөрөнгийн зах зээл дээр чөлөөтэй хөрвөдөг үнэт цаасны дериватив арилжаа хийж эхлээд байна.



ЖИЖИГ, ДУНД БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

▶▶ Үл хөдлөх эд хөрөнгийн зээл нь монгол улсын банк санхүүгийн салбарт бизнесийн зориулалттай урт хугацаат үл хөдлөх эд хөрөнгийн анхдагч бүтээгдэхүүн болсон бөгөөд жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжихэд үлэмж хувь нэмрийг оруулж байна. ◀◀

ЖДББГ нь жижиг, дунд бизнес /ЖДБ/ эрхлэгчдэд банкны үйлчилгээг хурдан шуурхай, чанарын өндөр түвшинд хүргэх, эдийн засагт гарч байгаа өөрчлөлтүүдэд мэдрэмжтэй хандаж, харилцагчдын санхүүгийн шинэ эрэлт хэрэгцээг судлан, банкны бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, харилцагчдад санхүүгийн мэргэжлийн зөвлөгөөг өгөх зорилтуудыг тавьж ажиллалаа.


Уг зорилтуудын хүрээнд ОУСК-тай хамтран ЖДБ эрхлэгчдэд зориулсан SME toolkit тусгай веб хуудсыг ажиллуулсан нь харилцагчдад өөрийн бизнесийг төлөвлөх, удирдах, бэлэн мөнгөний урсгалыг тооцох, борлуулалт, маркетингийн бодлогыг сайжруулах зэрэг нэн тэргүүний тулгамдсан асуудлуудын талаар үнэгүй зөвлөгөөг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг олгож байна.

ХХБ нь ЖДБ-ийг дэмжин харилцагчдад хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ нөхцлийг илүү таатай болгоход анхаарлаа хандуулж ирсэн билээ. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банк болон Японы олон улсын хамтын ажиллагааны банктай харилцаагаа гүнзгийрүүлж ЖДБ эрхлэгчдэд хамгийн бага хүүтэй, 10 хүртэлх жилийн төслийн зээлийг олгож байна. Түүнчлэн, харилцагчдын Тайвань болон Өмнөд Солонгосоос хийх худалдан авалтыг дэмжиж 3 хүртэлх жилийн хямд өртөгтэй эх үүсвэрээр санхүүжүүлж байна.

ЖДБ эрхлэгчдэд зориулж өөрийн эх үүсвэрээр бизнесийн зориулалттай, урт хугацааны “Үл хөдлөх эд хөрөнгийн зээл”-ийг гаргасан нь банк санхүүгийн салбарт цоо шинэ бүтээгдэхүүн болж чадсан бөгөөд энэ нь ЖДБ-ийн хөгжлийг дэмжихэд үлэмж их хувь нэмрийг оруулж байна.


Эдгээр ажлын үр дүнд тайлант онд нийтдээ 11.2 тэрбум төгрөгийн зээл олгож, оны эцсээр зээлийн үлдэгдэл 16.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 хувиар өссөн байна. ЖДББГ-ын зээлийн багцын өсөлтийг он дарааллаар харуулбал:

Жижиг, дунд байгууллагын банкны газрын зээлийн багцын өсөлт (Тэрбум төгрөг)




ЖДББГ-ын гол зорилгуудын нэг нь ЖДБ эрхлэгчдийг дэмжин, том харилцагчдын эгнээнд дэвшүүлэн шилжүүлэх явдал юм. Энэ ч утгаараа бид харилцагчиддаа илүү уян хатан нөхцөлтэй, урт хугацааны хөрөнгө оруулалтын зээлийг санал болгодог. Тайлант оны эцсээр зээлийн багцын ерөнхий ангилал болон зээлийн хугацааны ангилал:

Зээлийн багцын ерөнхий ангилал



Зээлийн багц хугацааны ангилалаар



ХХБ нь Монгол улсын эдийн засгийн бүхий л салбаруудад үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажилладаг нь дотоодын эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна.

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

▶▶ Тайлант оны эцсийн байдлаар ХХБ нь Монголбанкны үнэт цаасны 34.5%, Засгийн газрын бондын 38.1 хувиудыг эзэмшиж, тухайн зах зээлд тэргүүлэх байр суурьтай байна. ◀◀

Мөнгөний зах зээл


Мөнгөн хөрөнгийн удирдлагын гол зорилго нь Монголбанкнаас тавьсан банкны төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангах замаар хүүгийн болон хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэх, бэлэн мөнгөний урсгалыг зохицуулах, зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй дэмжихэд оршдог билээ.

ХХБ нь тайлант онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг хамгийн зохистой хэмжээнд хэрэгжүүлж ажилласны дээр өмнөх жилүүдийн адил Монголбанк болон Засгийн газрын үнэт цаасны арилжаанд идэвхитэй оролцлоо.

Тайлант оны эцсийн байдлаар ХХБ нь Монголбанкны үнэт цаасны 34.5%, Засгийн газрын бондын 38.1 хувиудыг эзэмшиж, тухайн зах зээлд тэргүүлэх байр суурьтай байна.

Түүнчлэн, улс орны хэмжээнд хүн амыг орон сууцжуулах зорилгоор хэрэгжүүлж буй “40 000 айлын орон сууц” хөтөлбөрийг дэмжиж, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2007 оны 2-р сарын 6-ны өдрийн 26 дугаар тогтоолын дагуу Монгол улсын Засгийн газраас гаргасан 90.0 тэрбум төгрөгийн бондын арилжаанд оролцон, нийт 11.6 тэрбум төгрөгийн 28-364 хоногийн хугацаатай бондод хөрөнгө оруулалт хийлээ.

ХХБ-ны мөнгөний зах зээлд эзлэх хувь



Гадаад валютын арилжаа

ХХБ нь Монгол улсын банк санхүүгийн системийг дэлхийн зах зээлд тодорхойлогч, тэргүүлэгч байр сууриа хадгалж, дотоодын арилжааны дийлэнх хувийг гүйцэтгэж байгаа билээ.

Тайлант онд дэлхийн санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлт хөдөлгөөнүүд бий болж, оны сүүлийн хагас жилд АНУ-ын мортгэжийн зах зээлд хямрал гарсан ч тус банк гадаад төдийгүй, дотоодын зах зээл дээрх үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, гадаад валютын арилжааны ашгийг 4.4 тэрбум төгрөгт хүргэлээ.

Улмаар тус банк дотоодын зах зээлд хамгийн олон төрлийн гадаад валютаар арилжаа хийдэг, валютын эргэлтийн хэмжээгээр тэргүүлэгчийн байр сууриа хадгалан бэхжүүлсээр байна.

Мөн валютын арилжаанаас хүлээж болзошгүй эрсдэлийг бууруулж, эргэлтийг нэмэгдүүлэх үүднээс санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг үргэлжлүүлэн нэвтрүүлсээр байна.

ХХБ-ны валютын арилжааны зах зээлд эзлэх хувь




Алтны арилжаа

Манай улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаагийн нэг гол шалтгаан нь уул уурхайн салбарын өсөлт хөгжилтэй холбоотой билээ. ХХБ нь 2000 оноос эхлэн аж ахуйн нэгж, байгууллагуудаас биет алт худалдан авч эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг нийт 120 орчим аж ахуйн нэгжүүдийн 80-тай нь хамтран ажиллаж байна.

Харилцагч үйлчлүүлэгчиддээ олон улсын зах зээлийн мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүргэх үүднээс алт болон валютын зах зээлийн ерөнхий тойм мэдээллийг долоо хоног бүр хүргэн ажиллаж байна. Түүнчлэн, тэдний эдийн засгийн тогтворгүй байдал, тухайлбал, инфляциас өөрсдийн хөрөнгийг хамгаалах болон ашиг олоход нь зориулж биет бус алтаар байршсан бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсний дээр энэ чиглэлийн үйлчилгээг дахин нэгээр нэмэгдүүлж, 2007 онд “Биет бус мөнгөний дансны үйлчилгээ”-г шинээр гаргаад байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд “Ашигт малтмалын хууль”-д оруулсан зарим нэг өөрчлөлтүүдтэй холбоотойгоор аж ахуйн нэгжүүдийн зүгээс биет алтаа банкинд худалдах нь харьцангуй багасч байгаа хэдий ч 2007 онд өмнөх онтой харьцуулахад 42.8 тэрбум төгрөгөөр их биет алт худалдан авсан байна.

ХХБ-ны биет алтны зах зээлд эзлэх хувь



Актив пассивын удирдлага

ХХБ тайлант онд актив пассивын удирдлагыг улам боловсронгуй болгож, үүсч болох санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэн, банкны төлбөрийн чадварыг найдвартай хангах үүднээс эрсдэл хамгийн бага байх түвшинд хөрөнгийг байршуулж, чанаргүй зээлийн үлдэгдлийг багасгах, улмаар урт хугацаанд тогтвортой, өртөг багатай эх үүсвэр татах зорилго тавьж ажиллалаа.

Эдгээрийн үр дүнд 2007 оны хавар тус банк Монголын арилжааны банкуудаас анх удаа төгрөгийн зээлийн хүүгийн хэмжээг ам.долларын зээлийн хүүгийн хэмжээтэй ижил түвшинд хүргэж чадсан бөгөөд үүний дүнд нийт зээлийн үлдэгдэл 2006 онтой харьцуулахад 59% хувь өсч, ашигт ажиллагаа нэмэгдэхэд ихээхэн нөлөөлсөн байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


Эрсдэлийн удирдлагын бодлогын гол зорилго нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаа, түүний хамрах хүрээ, арга хэлбэр, үйл ажиллагаанд банкны үүрч болох эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг тодорхойлж, холбогдох бодлого, журмаар хангах, эрсдэлийн удирдлага, хяналтын харьцангуй бие даасан тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын чиг хандлагад ойртуулах, эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж банкны эрсдэлийг бууруулахад оршдог.

2007 оны хувьд Эрсдэлийн удирдлагын газар нь эрсдэлийн удирдлагын механизмыг сайжруулж боловсронгуй болгох, зээлийн хяналтыг сайжруулах, нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн багцыг 3 хүртэл хувиар бууруулах, чанаргүй зээлийн төлөлтийг гүйцэтгүүлэх, эдийн засгийн гол салбаруудын санхүүжилтийн бодлого, зээлийн багцын төвлөрлийн бодлого болон зээлийн бодлогыг шинэчлэн боловсруулах зорилтуудыг тавин ажиллалаа.

Өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэх үүднээс ББГ-ын шинэ бүтэц зохион байгуулалттай үйл ажиллагаагаа уялдуулан, зээлийн судалгаанаас эхлээд зээл төлж дуусах хүртэлх хугацаанд хөндлөнгийн давхар хяналт тавьж ажилласан нь эрсдэлийг бууруулж, зээлийн чанарт эерэгээр нөлөөллөө. Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2006 оны эцэст 4.4 байсан бол 2007 оны эцэст 2 болж буурсан байна.

Чанаргүй зээлийн төлөлтийг гүйцэтгүүлэх зорилгоор тайлант оны 7-р сард бие даасан Тусгай активын хэлтэс байгуулагдсан ба түүний үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх зорилгоор Чанаргүй зээлийн хороо шинээр бий болсон. Үүний үр дүнд нийт 4.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг эргэн төлүүлсэн байна.


Тайлант онд банкны зээлийн бодлого, стратеги, улс орны эдийн засгийн нөхцөл байдал, үр ашигтай уялдуулан, эдийн засгийн гол салбаруудын санхүүжилтийн бодлогыг шинэчлэн боловсруулснаар зээлийн эрсдэлийг бууруулж, зээлийн эрсдэлийн удирдлагын механизмыг сайжруулав.



Салбараар олгосон зээл 2006 он



Салбараар олгосон зээл 2007 он



2007 онд салбаруудын зээлийн багцын чанарыг сайжруулах, хөндлөнгийн бие даасан хяналтын тогтолцоог бий болгоход түлхүү анхаарч ажилласан бөгөөд энэ ажлын хүрээнд салбаруудын эрсдэлийн шинжээчдийг ЭУГ-ын харьяанд нэгтгэж, бүх төрлийн зээл олголтын гүйлгээг төвлөрүүлсэн. Ингэснээр салбаруудын зээлийн багцын чанар өмнөх 2006 онд 4.4 хувь байсан бол 2007 онд 3.6 хувь болж буурсан байна.

Зах зээлийн эрсдэл

Тайлант онд эрсдэлийг үнэлэх олон улсын үнэлгээний VAR аргаар банкны зах зээлийн эрсдэлийг хэмжиж, санхүүгийн үндсэн хэрэгслүүдийн ханшийн өөрчлөлтөөс үүдэн банкны багцаас алдаж болох алдагдлыг хянан, удирдлагад мэдээлэх системийг сайжруулж ажилласан болно.

Банкны багцаас алдаж болох алдагдлыг бодитойгоор үнэлж буй эсэхийг тогтоохдоо буцаан тестлэх /backtesting/ аргыг хэрэглэдэг бөгөөд үүний үр дүнд VAR утгуудаас илүү гарсан ашиг алдагдлын тоо нь итгэлцлийн түвшинд харгалзан зөвшөөрөх хэмжээнд (BASEL-ийн хорооны шалгуурт) нийцэж байгаад хяналт тавьж ажиллалаа. Банкны багцаас алдаж болох алдагдлыг өндөр нарийвчлалтай тооцоолохын тулд олон улсын санхүүгийн зах зээлд өргөн ашиглагддаг нөхцөлт хэлбэлзлийн EWMA (Exponentially Weight Moving Average) аргыг ашиглаж эхэлсэн.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийг хянах, удирдах зорилгоор 2007 онд банкны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. Дотоод аудитын газрын үйл ажиллагаа, газрын бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн, чиг үүргийг өргөжүүлж, банкны үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтыг чангатган, ажлын үр дүнг ТУЗ-д шууд тайлагнадаг болсон нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, үйл ажиллагааны хяналтын механизмын үр нөлөөг дээшлүүлэх боломжийг бий болгож байна. Үйл ажиллагааны алдагдлаас сэргийлэхийн тулд харилцах болон хадгаламжийн дансанд хаалт тавьж, үл хөдлөх эд хөрөнгийн зээл, хасалт хийх ба хаалтыг цуцлах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх журмуудыг шинээр боловсрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Тайлант онд хүний нөөцийн удирдлага, хөгжлийг банкны өөрчлөлт, шинэчлэл, хөгжлийн стратегитай нягт уялдаа холбоотойгоор хэрэгжүүлэх зорилгыг тавьж, банкны эрхэм зорилгыг биелүүлж чадахуйц чадварлаг хамт олныг бүрдүүлэн, тэдний авьяас чадвар, нөөц боломжийг нээн хөгжүүлж, ёс зүйн өндөр түвшинд, үр дүнтэй ажиллах орчин нөхцлийг баттай бий болгох, мэргэшсэн алба төлөвшүүлэх, бүтцийн өөрчлөлт шинэчлэлтийг гүнзгийрүүлэх, ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллалаа.

Хүний нөөцийн удирдлагын бодлогын хүрээнд хүний нөөцийн төлөвлөлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлж, сул чөлөөтэй ажлын байранд мэргэжлийн чадварлаг хүмүүсийг сонгон ажиллуулах, ажиллах хүчнийг татах олон төрлийн эх сурвалжийг ашиглах замаар хамгийн шилдэг боловсон хүчнийг сонгон авах давуу талыг бататгах, үүгээрээ тухайн салбартаа хамгийн сонирхол татахуйц ажил олгогч байх зорилтоо хэрэгжүүллээ.

ХХБ-ны хүний нөөцийн удирдлагын нэг чухал зорилт бол ажилтны банкны хөгжил болон бизнест оруулж буй хувь нэмрийг бодитойгоор үнэлж, урамшууллын системд зохих ёсоор тусгах, энэ зорилгоор ажилтны гүйцэтгэлд бодит үнэлгээ өгөх тогтолцоог бүрдүүлэх асуудал байлаа. Энэ асуудлыг хэрэгжүүлэх зорилгоор ажилтнуудын ажлын үр дүнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, гүйцэтгэлийг тоо ба чанарын үзүүлэлтээр тооцох журмыг шинэчлэн мөрдсөнөөр ажилтнуудын урамшууллын хэмжээ ажлын гүйцэтгэлийн үр дүнтэй уялдаж, ажилтнуудын бодит орлого ч нэмэгдсэн байна. Улмаар 2007 онд хүний нөөцийн зардлын банкны нийт зардалд эзлэх хувийн жин өсч, өмнөх 2006 оныхоос 40 хувиар нэмэгдсэн байна.

Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнд тус банкны ажилтнуудын ажлын бүтээмж, мэргэшлийн үр чадвар бүх шатандаа дээшилж, ажиллах хүчний одоогийн бүтцийн цөм нь банкны үйл ажиллагааг идэвхтэй явуулах нөхцлийг хангасан өндөр мэргэшилтэй, чадварлаг боловсон хүчнээр бүрдэх болсон бөгөөд өнөөдрийн залуу ажилтнууд эдгээр туршлагатай ажилтнуудаасаа суралцан, цаашид богино хугацаанд өсч хөгжин, зах зээлийн шалгуурыг давж чадах туршлагатай ажилтнууд болох боломж бүрэн бүрдлээ.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг сургалтын хэрэгцээнд үндэслэн боловсруулах, байгууллагын соёлын судалгааг үндэслэн зорилтот сургалт хийх, шинээр ажилд орогсдод тодорхой хугацааны дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлж дүгнэх, ажилтан бүрийг мэргэжлийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөтэй болгох, сургалт явуулдаг мэргэшсэн байгууллагууд, их дээд сургуулиудтай хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг авлаа. Тайлант онд тус банкны нийт 542 ажилтан сургалтад хамрагдсан ба эдгээрийн 30 орчим хувь нь гадаад орны банкны байгууллага, зөвлөх үйлчилгээний байгууллагуудын сургалтад оролцсон байна.

Нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тус онд 300,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж тэтгэмж ажилтнууддаа олгосон ба энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад бараг 5 дахин өссөн байна. Мөн ажилтнуудынхаа орон сууцны асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2,5 тэрбум төгрөгийн зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон байна. Түүнчлэн, 364 ажилтанд тусгай нөхцөлтэй, зээлийн үйлчилгээ үзүүлжээ.

2007 онд ажил үйлсээрээ шалгарсан манай 46 ажилтан төрийн төв байгууллагууд, нийслэл, төрөлжсөн салбарын байгууллагуудын болон банкны шагналаар шагнагдсан байна.

Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

ХХБ нь анх үүсгэн байгуулагдсан цагаасаа компанийн нийгмийн хариуцлагаа сайтар хэрэгжүүлж эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спортын салбаруудыг дэмжиж ажилласан. 2007 оны хувьд бид дараах арга хэмжээнүүдийг ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Үүнд:

- Агаарын бохирдол ихтэй, хотын төвөөс алслагдсан ногоон байгууламжгүй хүүхдийн цэцэрлэгүүдэд мод тарьсан;
- Дархан хотын Соёл амралтын паркийг сэргээн тохижуулахад санхүүгийн туслалцаа үзүүлсэн;
- “Лотус” хүүхдийн асрамжийн төвд хандив, тусламж үзүүлсэн;
- Санхүү, эдийн засгийн их сургуулийн шинэ барилгын лекцийн танхимыг тохижуулж, оюутан, сурагчдад сурч боловсроход таатай орчинг бий болгосон;
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р тусгай сургуулийн шинэ жилийн баярыг тэмдэглэлцсэн;
- Урлагийн салбарын томоохонд тооцогддог “Пентатоник – 2007” наадмыг ивээн тэтгэж хамтран ажилласан;
- Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт галын аюулд нэрвэгдсэн ард иргэдэд хандив цуглуулан санхүүгийн дэмжлэг үзүүлсэн;
- Хүнд өвчнөөр өвчилсөн, амьдралын хүнд бэрхийг туулсан, өрх толгойлсон эмэгтэй Тунгалагийн /асан/ эмчилгээнд хандив өгсөн;
- Монголын соёлын өвийг залгамжлагч, уран бичгийг хөгжүүлэгч Д.Батбаяр АНУ-д монголын уран бичгийн үзэсгэлэн гаргахад нь санхүүгийн бүрэн дэмжлэг үзүүлсэн;
- Оюутны эрдэм шинжилгээний бага хурал болох “Эврика-2007” наадмын ерөнхий ивээн тэтгэгчээр ажилласан;
- “Чингис хаан 800 жилийн тэртээгээс эргэн ирсэн нь” наадмыг ивээн тэтгэсэн;
- Дорноговь аймаг дахь ноён хутагт, соён гэгээрүүлэгч Данзанравжаагийн музейг шинэчлэн сэргээн босгоход туслалцаа үзүүлсэн;
- Улсын аварга шалгаруулах шатрын тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажилласан;
- Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар, Туул голын эргийн орчмыг ХХБ-ны нийт ажилчид цэвэрлэсэн зэрэг болно.

Худалдаа Хөгжлийн Банк
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2007 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
жилийн санхүүгийн тайлан

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
Компанийн талаарх мэдээлэл

Албан хаяг
Улаанбаатар-11 Монгол Улс

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Компанийн нарийн бичгийн дарга

Хамтарсан аудиторууд

Жуулчны гудамж-7

Д.Эрдэнэбилэг (Дарга)
Д.Мөнхбаатар
Ч.Энхболд
Т.Цолмон
Т.Болдхүү

Д. Даваажав

KPMG
Куала Лумпур
Малайз улс


“Тэнцвэр оргил аудит” ХХК
Улаанбаатар
Монгол Улс

Захирлууд болон удирдлагын мэдэгдэл


Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ны (цаашид “Банк” гэх) ТУЗ-ийн дарга Д.Эрдэнэбилэг миний бие болон банкны санхүүгийн асуудал хариуцсан захирлууд болох Рандолф Коппа, Б.Мэдрээ Д.Янжмаа нар энэхүү тайлангийн 4-48 дугаар хуудсанд үзүүлсэн 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг МонголБанкнаас тодорхойлон гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг баталгаажуулж байна.




Д.Эрдэнэбилэг
ТУЗ-ийн дарга



Б. Мэдрээ
Гүйцэтгэх захирал



Рандолф Коппа
Ерөнхийлөгч



Д.Янжмаа
Санхүүгийн Бүртгэл,
Хяналтын Газрын захирал



KPMG (Firm No.AF 0758)
Chartered Accountants
Wisma KPMG
Jalan Dungun, Damansara Heights
50490 Kuala Lumpur, Malaysia



Тэнцвэр Оргил Аудит ХХК
402 тоот, Хатан Сүйх Компанийн байр
ЗӨЧ, 8-р хороо, СБДүүрэг
Улаанбаатар, Монгол Улс
Утас/Факс: 976-11-324496

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн гишүүдэд хүргэх аудитын тайлан

Бид 4-48 дугаар хуудсанд үзүүлсэн Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн тайланд аудит хийлээ. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах нь банкны захирлуудын үүрэг байдаг.


Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргаж, өөр аливаа нэг зорилгод биш зөвхөн та бүхэнд тайлагнах нь бидний үүрэг юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангуудыг материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангууд дахь дүн, тодруулгуудын дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажиллагаа багтдаг. Мөн аудитын ажилд захирлуудын хийсэн томоохон тооцоолууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ зохистой тайлагнагдсан эсэхэд үнэлэлт өгөх ажлууд орно. Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэлийг хангаж өгнө гэдэгт бид итгэлтэй байна.

Бидний дүгнэлтээр Энэхүү санхүүгийн тайлангууд нь 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг МонголБанкнаас тодорхойлон гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв үзүүлсэн байна.

KPMG

KPMG
Мэргэшсэн нягтлан бодогч
Байгууллагын дугаар: AF 0758



Тэнцвэр Оргил Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогч
Лицензийн дугаар: 056/2006

Улаанбаатар, Монгол Улс

Огноо: 2008 оны 3 дугаар сарын 14

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн гишүүдэд хүргэх аудитын тайлан

Бид 4-48 дугаар хуудсанд үзүүлсэн Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн тайланд аудит хийлээ. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах нь банкны захирлуудын үүрэг байдаг.

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргаж, өөр аливаа нэг зорилгод биш зөвхөн та бүхэнд тайлагнах нь бидний үүрэг юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангуудыг материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангууд дахь дүн, тодруулгуудын дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажиллагаа багтдаг. Мөн аудитын ажилд захирлуудын хийсэн томоохон тооцоолууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ зохистой тайлагнагдсан эсэхэд үнэлэлт өгөх ажлууд орно.

Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэлийг хангаж өгнө гэдэгт бид итгэлтэй байна.

Бидний дүгнэлтээр Энэхүү санхүүгийн тайлангууд нь 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг МонголБанкнаас тодорхойлон гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв үзүүлсэн байна.

KPMG
Мэргэшсэн нягтлан бодогч
Байгууллагын дугаар: AF 0758

Тэнцвэр Оргил Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогч
Лицензийн дугаар: 056/2006

Улаанбаатар Монгол Улс
2008 оны 3 дугаар сарын 14

Тайлан тэнцэл

	Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
АКТИВ			
Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах зүйл	4	110,375,937	134,943,033
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	5	46,424,127	27,584,472
Зээл ба урьдчилгаа	6	382,308,143	240,106,085
Хоёрдогч өглөг	7	4,000,000	-
Үндсэн хөрөнгө	8	11,683,487	12,225,512
Биет бус хөрөнгө	9	1,004,359	829,942
Бусад хөрөнгө	10	7,707,071	10,603,078
НИЙТ АКТИВ		563,503,124	426,292,122
ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Пассив			
Харилцагчдын харилцах, хадгаламж	11	373,018,621	324,669,447
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж	12	15,261,624	9,583,124
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	13	7,387,649	26,458,098
Татварын өглөг		1,455,320	1,230,053
Гаргасан өрийн хувьцаа	14	86,661,743	-
Бусад пассив	15	10,088,345	5,331,398
Нийт хадгаламж, зээл, татвар, бусад өр төлбөр		493,873,302	367,272,120
Хоёрдогч өглөг	16	9,359,760	9,320,000
Нийт пассив		503,233,062	376,592,120
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	17	6,610,113	6,610,113
Бусад нөөц		6,338,749	12,171,762
Хуримтлагдсан ашиг		47,321,200	30,918,127
Нийт өөрийн хөрөнгө		60,270,062	49,700,002
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		563,503,124	426,292,122

53-88 дахь хуудас нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэгэн хэсэг болно.

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
 Орлого үр дүнгийн тайлан

	Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
Хүүгийн орлого	19	47,322,951	36,037,323
Хүүгийн зардал	20	(26,675,606)	(14,588,934)
Хүүгийн цэвэр орлого		20,647,345	21,448,389
Хураамж шимтгэлийн цэвэр орлого	21	6,287,916	4,576,908
Үйл ажиллагааны бусад орлого	22	4,138,548	4,285,087
Хүүгийн бус цэвэр орлого		10,426,464	8,861,995
Үйл ажиллагааны орлого		31,073,809	30,310,384
Үйл ажиллагааны зардал	23	(13,696,975)	(12,190,069)
Үнэлгээний бууралтын алдагдлын хасагдуулга	24	2,571,664	(1,630,679)
Татварын өмнөх ашиг		19,948,498	16,489,636
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	25	(3,552,346)	(4,715,698)
Татварын дараах цэвэр ашиг		16,396,152	11,773,938

53-88 дахь хуудас нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэгэн хэсэг болно.

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
Өмчийн өөрчлөлтийн тайлан

Ул хуваарилагдах Хуваарилагдах

Торгууль	Ул хуваарилагдах			Хуваарилагдах		
	Хувьцааг капитал мян.төг	Нэмж төлөгдсөн хувьцаа мян.төг	Хувьцаа мян.төг	Дахин үнэлээний сан мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт мян. төг
2006 оны I сарын 1-ний үлдэгдэл	6,607,477	7,375,322	-	4,780,582	19,077,657	37,841,038
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	11,773,938	11,773,938
Гаргасан хувьцаат капитал	2,636	16,870	-	-	-	19,506
Хөрөнгөөр төлсөн хувьцааны төлбөр	-	-	-	-	65,520	65,520
Шилжүүлсэн нөөц	-	-	-	(1,012)	1,012	-
2006 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,610,113	7,392,192	-	4,779,570	30,918,127	49,700,002
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	-	16,396,152	16,396,152
Шилжүүлсэн нөөц	-	-	-	(6,921)	6,921	-
Хувьцааны төлбөр	18	-	(5,826,092)	-	-	(5,826,092)
2007 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,610,113	7,392,192	(5,826,092)	4,772,649	47,321,200	60,270,062

53-88 дахь хуудас нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэгэн хэсэг болно.

Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	19,948,498	16,489,636
<i>Тохируулга</i>		
Элэгдэл, хорогдол	1,443,208	1,048,332
Данснаас хассан үндсэн хөрөнгө	284,242	45,226
Данснаас хассан биет бус хөрөнгө	11,583	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз /(гарз)	1,761	(1,350)
Үнэлгээний бууралтын алдагдлын сан	(2,571,664)	1,630,679
Хувьцааны төлбөрт зориулсан гүйлгээ	-	65,520
Үйл ажиллагааны актив, пассивийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	19,117,628	19,278,043
Зээл ба урьдчилгааны өсөлт	(138,575,907)	(83,302,894)
Олгосон хоёрдогч өглөг	(4,000,000)	-
Бусад хөрөнгийн бууралт (өсөлт)	1,870,571	(5,699,989)
Харилцагчдын харилцах, хадгаламжийн өсөлт	48,349,174	98,436,252
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламжийн өсөлт (бууралт)	5,678,500	(1,186,701)
Бусад өр төлбөрийн өсөлт (бууралт)	4,767,656	(73,592)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(62,792,378)	27,451,119
Төлсөн аж ахуй нэгжийн орлогын албан татвар	(3,327,079)	(4,336,903)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(66,119,457)	23,114,216
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалтын үнэт цаасны цэвэр өсөлт	(18,640,655)	19,101,555
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(1,448,273)	(3,486,866)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(400,235)	(566,114)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	475,322	25,617
Худалдан авсан хувьцаагаарх үнэт цаас	(199,000)	(61,350)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(20,212,841)	15,012,842

Тодруулга	2007 мян.төг	2006 мян.төг
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хувьцааны орлого	-	19,506
Санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн орлого	(19,070,449)	14,014,837
Өрийн хувьцааны орлого	86,661,743	-
Мөнгөн сангийн хувьцаа	(5,826,092)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	61,765,202	14,034,343
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	(24,567,096)	52,161,401
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эхний үлдэгдэл	134,943,033	82,781,632
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эцсийн үлдэгдэл	4 110,375,937	134,943,033

53-88 дахь хуудас нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэгэн хэсэг болно.

1. Банкны талаарх мэдээлэл ба үндсэн үйл ажиллагаа

2007 оны 1 сард Жералд Металс компани нь өөрийн эзэмшлийн Глобул Инвестмент энд Девелопментийн бүх хувьцааг Ю.С. Глобал Инвестмент ХХК-д зарснаар Банкны толгой компани нь Ю.С. Глобал Инвестмент ХХК болсон билээ. Ю.С. Глобал Инвестмент” компани нь Улаанбаатар Хотын Банк, Капитрон Банк, Сэнтрал Азия Майнинг ХХК болон тус банкны одоогийн ТУЗ-ийн дарга Должингийн Эрдэнэбилэг нарын байгуулсан консорциум юм.

Худалдаа Хөгжлийн Банк ХХК (цаашид “Банк” гэх) нь Монгол улсад байршдаг. Тус Банк нь МонголБанкнаас олгосон 8 тоот лицензийн дагуу банкны болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл ажиллагаа явуулдаг. Тус санхүүгийн жилийн явцад үндсэн үйл ажиллагааны цар хүрээнд ямар нэгэн томоохон өөрчлөлт гараагүй байна.

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн 2008 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн шийдвэрийн дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.

2. Санхүүгийн тайлангийн бэлтгэлийн үндэслэл

(а) Нийцэлтийн талаарх мэдэгдэл

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлийн (ОУНББСЗ) хэрэглэдэг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон ОУНББСЗ-ийн Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарт нийцүүлэн бэлтгэсэн бөгөөд уг тайлбарыг Монгол Банк тодорхойлон заавар гаргасан болно.

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэн гаргахдаа Банк нь 2007 оны 1 сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 1 Санхүүгийн тайлан гаргах тухай – Капиталыг тайланд тусгах тухай заалт болон СТОУС 7 Санхүүгийн бичиг баримт, акт: Тайланд тусгах тухай заалтыг тус тус хэрэглэжээ. СТОУС 7 болон НББОУС 1-д оруулсан өөрчлөлтийг хэрэглэсэн нь энэхүү санхүүгийн тайланд тусгасан үзүүлэлтүүдийн шинж, цар хүрээнд нөлөө үзүүлсэн боловч, Банкны тайлагнасан санхүүгийн байр суурь болон ашигт нөлөө үзүүлээгүй байна. Стандартуудын өөрчлөлтийн шаардлагуудын дагуу Банк бүрэн дүүрэн, харьцуулсан мэдээллийг хангаж өгсөн байна.

(б) Үнэлгээний үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг зах зээлийн өртгөөр нь тусгадаг үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон борлуулахад бэлэн буй санхүүгийн хөрөнгүүдийг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.

(в) Тайлан гаргасан болон үйл ажиллагааны валют

Тайланг төгрөгөөр, нэгжийн оронг мянгачилан гаргасан болно. Монгол төгрөг нь тус банкны үйл ажиллагааны валют юм.

(г) Ойролцоо тооцоолол болон дүгнэлт шийдвэрүүдийн хэрэглээ

Санхүүгийн тайлангуудын хувьд тус Банкны удирдлагын зүгээс шийдвэр, дүгнэлт гаргах, мөн ойролцоо тооцоолол хийх, таамаглал хийх шаардлагатай байдаг. Эдгээр шийдвэр,

дүгнэлт, ойролцоо тооцоолол, таамаглал нь санхүүгийн тайлангуудад хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, тайлагнасан актив, пассив, орлого, зарлагын дүнд нөлөөлдөг тул бодит гүйцэтгэл нь дээрх таамаглал, ойролцоо тооцооноос өөр байж болзошгүй юм. Тооцоолол болон суурь таамаглалыг тогтмол хянаж байдаг. Бүртгэлийн тооцоонд засвар орвол тухайн засвар орсон тайлант үе болон уг засвар нөлөөлөх ирээдүйн тайлант үеийн тайлангуудад тусгагдана.

Санхүүгийн тайланд тусгагдсан мөнгөн дүнд томоохон нөлөө үзүүлсэн тооцооллын хувьд тодорхойгүй зүйлсийн талаарх мэдээлэл болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд хийсэн шийдвэрлэх дүгнэлт, шийдвэрүүдийн талаар мэдээллийг тусгайлан Тодруулга 27 болон Тодруулга 28-д үзүүлэв.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Доор тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг Банк тууштай хэрэглэдэг бөгөөд өнгөрсөн жил хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудтай тохирч байна.

(а) Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар хийсэн гүйлгээг тайланд тусгахдаа тухайн гүйлгээ хийсэн өдөр зонхилж буй гадаад валютын ханшны дагуу валютыг монгол төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Түүхэн өртгөөр бүртгэлд тусгагддаг гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тухайн өдрийн валютын ханшаар монгол төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Валютыг монгол төгрөгт хөрвүүлэхтэй холбоотой үүссэн валютын ханшны зөрүүг орлогын тайланд тусгадаг. Зах зээлийн нэрлэсэн үнээр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг тухайн зах зээлийн ханшийг тодорхойлж буй өдрийн валютын арилжааны ханшид үндэслэн монгол төгрөгт хөрвүүлж тэмдэглэдэг.

(б) Санхүүгийн хэрэгслүүд

(i) Ангилал

Арилжааны хэрэгслүүдэд Банк нь үндсэндээ богино хугацаанд арилжаалах, төлбөрийн чадварын удирдлагын зорилгоор эзэмшиж байгаа хэрэгслүүд орно. Үүнд тодорхой дериватив гэрээнүүдийг хамруулах бөгөөд эдгээрийг ханшны зөрүүнээс ашиг олж болох үр дүнтэй хэрэгсэл гэж тодорхойлохгүй. Цэвэр авлагын позицтай (эерэг бодит үнэ цэнэтэй) арилжааны бүх деривативүүд болон худалдан авсан опционуудыг арилжааны хөрөнгө гэж тайлагнана. Цэвэр өглөгийн позицтай (эсрэг бодит үнэ цэнэтэй) арилжааны бүх деривативууд мөн гаргасан опционуудыг арилжааны өр төлбөр гэж тайлагнана.

Үүсгэсэн зээл ба авлагад богино хугацаанд арилжаалагдах зорилгоор бий болгосон хэрэгслүүдээс бусад, харилцагчдад олгосон зээл болон авлагууд орно. Үүнд харилцагчдад олгож буй зээл ба урьдчилгаа багтана.

Төлөх хугацаа хүртэл эзэмших хөрөнгөд Банк төлөгдөх хугацаа хүртэл эзэмших зорилготой, эзэмшиж болох тогтсон хугацаатай, тогтсон эсвэл тодорхойлж болох хэмжээний төлбөр бүхий санхүүгийн хөрөнгүүд орно. Үүнд Банкны эзэмшиж буй тодорхой хөрөнгө оруулалтын үнэт цаас багтана.

Борлуулах боломжтой хөрөнгөд арилжааны бус зорилгоор Банк эзэмшиж байгаа Банк өөрөө үүсгээгүй эсвэл барьцаанд аваагүй хөрөнгүүд орно.

(ii) Тайланд эхний удаа тусгах нь

Банк санхүүгийн хэрэгслүүдийг худалдаж авах эсвэл гаргах үед санхүүгийн хэрэгслүүдийг өртгөөр нь эхэлж бүртгэдэг бөгөөд энэ нь бодит үнэ цэнэтэй нь тэнцэнэ.

Хэрэв ямар нэгэн арилжаа, гүйлгээ нь зах зээлийн үнэд тулгуурлаагүй эсвэл зах зээлийн үнийг нь шууд тодорхойлох боломжгүй бол, ирээдүйд гарах төлбөр, орох орлогын ойролцоо тооцооллыг ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээлийн хүүгийн өнөөгийн үнэ цэнийг үндэс болгож бодит өртгийг ойролцоогоор тогтоодог. Санхүүгийн хэрэгслийн бодит өртөг болон зах зээлийн үнийн зөрүүг Санхүүгийн Тайлан Бэлтгэх Олон Улсын Стандартын холбогдох заалтын дагуу хөрөнгө, өр төлбөр хэмээн тодорхойлогдох боломжгүй л бол шууд орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(iii) Удаах үнэлгээ

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа идэвхтэй зах зээл дээр зах зээлийн санал болгох үнэгүй бөгөөд зах зээлийн бодит үнийг тодорхойлох боломжгүй хөрөнгүүдээс бусад бүх арилжааны хэрэгсэл, худалдах боломжтой хөрөнгүүд нь зах зээлийн үнээрээ хэмжигдэн, анхны өртгөөс үнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр өртгөөр тусгагддаг. Арилжааны хэрэгслүүд, худалдах боломжтой хөрөнгийн бодит үнийн өөрчлөлтөөс үүсэх ашиг алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба өмчийн өөрчлөлтийн тайланд шууд тусгадаг байна.

Арилжааны бус зориулалттай санхүүгийн өр төлбөрүүд, анхдагч зээл болон авлага, дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан үнэлгээний бууралтын алдагдлынх нь дүнгээр хорогдуулж бүртгэдэг. Ажил гүйлгээний өртгийг хамруулсан урамшуулал болон хөнгөлөлтийн дүнг холбогдох санхүүгийн хэрэгслийн нэрлэсэн үнэд шингээдэг бөгөөд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан тооцдог.

(в) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, Монголбанк болон бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ.

(г) Зээл ба урьдчилгаа

Банкнаас олгосон зээл ба урьдчилгааг Банкнаас олгосон зээл ба авлага гэж ангилдаг. Зээл болон урьдчилгаа гэдэг нь нь тооцоолсон эргэн төлөгдөх дүнг харуулах зорилгоор тайлагнасан цэвэр мөнгөн дүн юм. (Тодруулга 3 (и) хэсгийг үзнэ үү)

(д) Үндсэн хөрөнгө

(i) Өртөг

Хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл (доорх хэсгээс үзнэ үү) болон үнэ цэнийн бууралтын алдаглыг (Тодруулга 3 (и) хэсгийг үзнэ үү) хасаж

тооцдог. Хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ, импортын гаалийн татвар, эргэн төлөгдөх нөхцөлгүй худалдан авалтын татвар болон хөрөнгийг товлосон газарт нь хүргэн зориулалтаар ашиглалтанд оруулахтай холбогдон гарах шууд зардлуудаас бүрддэг. Хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулсны дараа гарсан урсгал засвар, үйлчилгээ болон их засварын зардлыг тухайн зардал гарсан тайлант жилийн орлогын тайланд тусгадаг. Гарсан зардал нь хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн хэрэглээнээс ирээдүйд олно гэж тооцоолсон эдийн засгийн үр ашгийг анх тогтоосон стандарт гүйцэтгэлийн үр ашгаас давуулан нэмэгдүүлсэн болохыг тодорхой харуулах боломжтой тохиолдолд уг зардлыг хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн нэмэлт зардал болгон капиталжуулна.

Банк нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бодит үнэ болон дансны үнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх зорилгоор дахин үнэлгээг тогтмол хийдэг.

Дахин үнэлгээнээс бий болсон илүүдэл нь дахин үнэлгээний нөөцийн дансанд бүртгэгдэх ба бий болсон дутагдал нь тухайн хөрөнгийн өмнөх жилийн өсөлтөөс хэтрэхгүй дүнгээр дахин үнэлгээний нөөцийн данснаас хасдаг. Бусад тохиолдолд, хөрөнгийн дансны үнийн бууралт нь орлогын тайланд тусгагдана.

(ii) Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Банкны үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа дараах байдалтай байна:

• Барилга	40 жил
• Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10 жил
• Компьютер	3-5 жил

(e) Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга нь бүрэн дуусаагүй буюу суурилуулаагүй шинэ барилгуудын өртгийг илэрхийлнэ. Дуусаагүй барилгад ямар нэгэн элэгдэл байгуулдаггүй.

(ё) Биет бус хөрөнгө

(i) Гудвилл

Гудвилл нь хөрөнгийн худалдан авалтын өртөг тухайн хөрөнгийн цэвэр нэрлэсэн үнээс илүү гарсан дүнгээр илэрхийлэгддэг бөгөөд үнэлгээний бууралтын алдагдлын дүнг хассан өртгөөр тусгагддаг. (Тодруулга 3 (ж) хэсгийг үзнэ үү)

(ii) Худалдан авсан биет бус хөрөнгө

Банкны худалдан авсан биет бус хөрөнгийг түүний хуримтлагдсан элэгдэл болон үнэлгээний бууралтын алдагдлыг хассан өртгөөр тусгадаг. (Тодруулга 3 (ж) хэсгийг үзнэ үү)

(iii) Хорогдуулга

Ашиглалтын хугацаа нь тодорхой биш биет бус хөрөнгөөс бусад биет бус хөрөнгийн

тооцоолсон ашиглалтын хугацааны туршид хорогдуулгыг орлогын тайланд шулуун шугамын аргаар тусгадаг. Тооцоолсон ашиглалтын хугацаа нь доор үзүүлсний дагуу байна. Үүнд:

Програм хангамж, лиценз

3-5 жил

(ж) Үнэлгээний бууралт

Банкны хөрөнгийн дансны үнийг тайлан баланс гаргах бүр тооцдог бөгөөд ингэхдээ ямар нэг үнэлгээний бууралтын алдагдал байгаа эсэхийг шалгадаг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл тухайн хөрөнгийн нөхөж болох дүнг тооцож гаргадаг.

(i) Анхдагч зээл ба урьдчилгаа

Зээл болон урьдчилгааг болзошгүй алдагдлын санг хассан цэвэр дүнгээр нь тайлагнадаг. МонголБанкнаас гаргасан журмын дагуу хасагдуулгыг балансын тогтмол хяналтын үр дүнд алдагдал үүсч болзошгүй хэмээн тодорхойлсон зээл эсвэл урьдчилгааны эргэн төлөгдөх боломжтой цэвэр дүнг тодорхойлох зорилгоор тогтмол байгуулж тэдгээрийн дансны үнээс нь хасч бүртгэдэг. Хасагдуулгын дансны өсөлтийг орлогын тайланд тусгадаг. Хэрэв олгосон зээлийг эргэн төлөгдөх боломжгүй болсон гэж үзвэл, хуулийн хүрээнд зохих бүхий л арга хэмжээг авах бөгөөд гарч болох алдагдлын нийт дүнг тодорхойлж тухайн зээлийг данснаас шууд хасдаг.

Хэрэв алдагдлын хэмжээ нь хожим багассан байна гэж тодорхойлогдсон бөгөөд энэхүү бууралт нь хасалт хийгдсэнээс хойш болсон ямар нэгэн үйл явдалтай холбоотой бол хасалдуулгыг буцааж орлогын тайланд залруулга хийдэг.

(ii) Зээл болон урьдчилгаанаас бусад хөрөнгө

Эргэн нөхөгдөх боломжтой дүн нь хөрөнгийн борлуулах цэвэр боломжит үнэ ба ашиглалтанд байгаа үнэ цэнийн аль илүү нь болж өгдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тухайн үеийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийг тусгадаг татварын өмнөх хямдруулалтын түвшинг ашиглан тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл нь хямдруулж ашиглалтанд байгаа үнэ цэнийг үнэлнэ. Мөнгөний орох урсгал бий болгодоггүй, бусад хөрөнгөөс тусдаа хөрөнгүүдийн хувьд эргэн нөхөгдөх дүнг тухайн хөрөнгийн харьяалагдаж буй мөнгө орох урсгал бий болгодог хөрөнгийн нэгжийн хувьд тодорхойлдог. Хөрөнгийн эсвэл мөнгө орох урсгал бий болгодог хөрөнгийн нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөж болох үнээсээ давсан үед үнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд тусгагддаг.

Эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан ойролцоо тооцоололд өөрчлөлт орсон бол үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй бол тодорхойлогдсон элэгдэл хорогдлыг хассан цэвэр дансны өртгөөс тухайн хөрөнгийн дансны үнэ хэтрэхгүй байх нөхцөлд л үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Үнийн бууралтын алдагдлын бүх буцаалтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(з) Буцаан худалдан авалтын гэрээнүүд

Банк нь тодорхой хугацаанд, тогтсон үнээр мөн чанарын хувьд ижил төрлийн хөрөнгө оруулалтыг дахин худалдан авах (худалдах) гэрээний дагуу хөрөнгө оруулалтыг эргэн худалдан авах (эргэн худалдах) үйл ажиллагаа явуулдаг. Дараа нь эргэн худалдах эсвэл эргэн худалдан авах нөхцөлтэй хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөхгүй.

Төлсөн дүнг банкуудад эсвэл харилцагчдад олгосон зээлийн дансанд бүртгэдэг. Авлагуудыг тухайн үнэт цаасаар барьцаалагдсан гэж бүртгэдэг. Эргэн худалдан авалтын гэрээний хүрээнд борлуулсан хөрөнгө оруулалтуудыг балансад тусгаж үлдээдэг бөгөөд мөнгөн дүнг нь арилжааны үнэт цаас эсвэл борлуулах боломжтой үнэт цаасны бүртгэлийн бодлогын аль тохиромжтойг нь хэрэглэж тооцож гаргадаг. Хөрөнгө оруулалт борлуулснаас орох орлогыг банк эсвэл харилцагчдад өгөх өглөг гэж бүртгэлд тусгадаг. Борлуулалт болон дахин худалдан авалтын зөрүүг тайлант үеийн турш хуримтлуулах суурьтай (аккруэл суурьтай) бүртгэлийн аргаар бүртгэж дансанд тусгадаг ба хүүгийн дүнд ордог.

(и) Арилжааны бус санхүүгийн өр төлбөр

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр гэдэгт харилцагчид, бусад санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламж, хүү бүхий зээллэг болон бусад өглөгүүд орно. Арилжааны бус өр төлбөрийг анх өртгөөр нь тусгадаг. Эхний хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр нь хорогдуулсан өртөг буюу өртөг болон үлдэх өртгийн хоорондын зөрүүгийн хамт тусгагдан, үр ашигт хүүгийн аргаар тухайн хэрэгслийн хугацааны турш орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

(й) Хувьцаат капитал

(i) Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг өмч гэж ангилдаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион гаргахтай шууд холбогдон гарах өсөн нэмэгдэх өртгийг татварын нөлөөнөөс ангид цэвэр өмчийн суутгал гэж бүртгэдэг.

(ii) Мөнгөн сангийн хувьцаа

Өмч хэмээн бүртгэгдсэн хувьцаат капиталыг дахин худалдан авсан тохиолдолд төлсөн хураамж нь ямар нэг татварын нөлөөгүй цэвэр байх бөгөөд өмчийн суутгал гэж бүртгэгдэнэ. Гэхдээ хураамжид шууд хамаарах зардлыг оруулж тооцно. Дахин худалдан авсан хувьцааг мөнгөн сангийн хувьцаа гэж үзэх бөгөөд нийт өмчөөс суутгасан суутгал гэж бүртгэнэ. Мөнгөн сангийн хувьцааг борлуулах эсвэл удаалан дахин гаргасан тохиолдолд хүлээн авсан мөнгөн дүнг өмчийн өсөлт гэж бүртгэх ба гүйлгээнээс улбаалан гарсан илүүдэд эсвэл алдагдлыг хуримтлагдсан ашиг руу шилжүүлэх буюу эсвэл хуримтлагдсан ашгаас хасна.

(к) Болзошгүй эрсдлийн сан

Банк нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны буюу бодит хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гарах урсгалд хариуцлагаа биелүүлэх шаардлагатай байх үед балансад болзошгүй эрсдлийн санг хүлээн тусгадаг. Нөлөөлөл нь материаллаг бол мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн үнэлгээг тусгадаг татварын өмнөх түвшин болон тохиромжтой бол тухайн өр төлбөрт хамааралтай эрсдлээр нь ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хямдруулах замаар болзошгүй эрсдлийн сангийн дүнг тодорхойлдог.

(л) Орлого

(ii) Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж, хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлого зардал нь хямдруулалт буюу урамшуулал, хүү бүхий хэрэгслийн дансны үнэ болон үр ашигт хүүгийн түвшний сууриар тооцсон дуусгавар хугацаан дахь дүнгийн хоорондын зөрүүний, хорогдлыг агуулдаг.

(iii) Хураамж шимтгэлийн орлого

Хураамж шимтгэлийг үзүүлсэн санхүүгийн үйлчилгээнийхээ төлөө харилцагчдаас авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүлээн зөвшөөрдөг.

(iv) Түрээсийн орлого

Түрээслэсэн хөрөнгийн түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын салшгүй хэсэг болон тусгагддаг.

(м) Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Түрээсийн зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар орлогын тайланд тусгагддаг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын салшгүй хэсэг болгон орлогын тайланд түрээсийн нийт хугацааны хувьд тусгадаг.

(н) Орлогын татвар

Тайлант жилийн ашиг эсвэл алдагдалд ногдох орлогын татвар нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Өмчөөр шууд хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл бүхий зүйлстэй холбоотой татварыг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Үүнээс бусад тохиолдолд орлогын татварыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар нь балансын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувийг ашиглан тооцсон тухайн жилийн татвар ногдох орлогод ногдуулсан хүлээгдэж буй татварын өглөг болон өмнөх жилүүдийн татварын өглөгт хийсэн залруулга болно.

Хойшлогдсон татварыг балансын өр төлбөрийн аргыг ашиглан, санхүүгийн тайлангийн зорилгоор тооцоолсон дүн болон татварын зорилгоор тооцоолсон хөрөнгө өр төлбөрийн дансны үнийн дүнгийн хоорондох түр зөрүүгээр тооцоолдог. Нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох орлогод нөлөөлөхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлттэй холбоотой түр зөрүүнд хойшлогдсон татварыг тооцоолдоггүй.

(о) Ажиллагсдын тэтгэмж

(i) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Ажиллагсдын тэтгэмж нь улсын нийгмийн даатгалын байгууллагад төлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг агуулдаг. Энэхүү тодорхойлсон тэтгэмжийн төлөвлөгөөний тусламжийг гарсан үед нь орлогын тайланд зардлаар тусгагддаг.

(ii) Хувьцааны урамшуулалд үндэслэсэн төлбөрийн гүйлгээнүүд

Ажиллагсдад опционы эрх өгсөн өдрийн зах зээлийн үнээр хүний нөөцийн зардалд бичин цаашид уг опционыг авах эрхтэй болох хугацааны туршид нөгөө талд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ. Зардал болох дүнг эрхийг нь олгосон хэрэгжүүлээгүй үлдсэн опционы тоогоор тохируулна. Ажиллагсдын опционы эрхийн зах зээлийн үнийг Black-Scholes томъёогоор тооцсон. Хэмжигдсэн өдрийн хувьцааны үнэ, хэрэгслийг хэрэгжүүлэх үнэ, хүлээгдэж байгаа хэлбэлзэл (олон нийтэд зарлагдсан мэдээллүүдээс шалтгаалсан өөрчлөлтүүдийг тусгасан жигнэсэн дундаж түүхэн хэлбэлзлэлд үндэслэсэн), хэрэгслийн хүлээгдэж буй хэрэгжих хугацааны жигнэсэн дундаж (түүхэн туршлага ба хувьцаа эзэмшигчдийн ерөнхий зан араншинд тулгуурласан) зэрэг нь өгөгдөлд орсон болно. Зах зээлийн үнийг тодорхойлохдоо гүйлгээтэй холбогдсон үйлчилгээ ба зах зээлийн бус гүйцэтгэлийн нөхцөлүүдийг авч үзээгүй болно.

(ө) Хэрэгжүүлж эхлээгүй байгаа шинэ стандартууд ба тайлбарууд

Олон тооны СТОУС-ууд, СТОУС-уудын нэмэлтүүд болон тайлбарууд (Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хороо (НББОУСХ)) нь 2007 оны 12-р сарын 31-ны өдрөөр төгссөн онд хүчин төгөлдөр болоогүй байсан бөгөөд эдгээр санхүүгийн тайланд тусгагдаагүй болно:

- СТОУС 8 Үйл ажиллагааны сегмент нь сегментийн тайлан гаргах ‘менежментийн арга’-ыг хангаж өгдөг. Тус Банкны 2009 оны санхүүгийн тайланд заавал дагаж мөрдөх ёстой стандарт болох СТОУС 8 нь сегмент нэг бүрийн үйл ажиллагааг үнэлж, нөөцийг тэдэнд хуваарилахын тулд Банкны үйл ажиллагааны гол шийдвэрүүдийг гаргагчид тогтмол хянадаг дотоод тайланд үндэслэн сегментийн мэдээллийг гаргахыг шаардана. Банк одоогоор бизнесийн дан ганц нэгжийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа тул энэхүү СТОУС нь тайлангалын шаардлагад нөлөө үзүүлэхгүй.
- СТОУС 11 СТОУС 2 – Бүлэг болон Мөнгөн сангийн хувьцааны гүйлгээ нь байгууллага өмчийн хэрэгслийг хэрхэн олж авсныг харгалзахгүйгээр өмчөөр төлсөн хувьцаагаарх төлбөрийн гүйлгээ гэж тайланд тусгах өөрийн өмчийн хэрэгслийн хураамж болгон бараа, үйлчилгээ хүлээн авч буй хувьцаагаарх төлбөрийн зохицуулалтыг шаарддаг. СТОУС 11 нь тус Банкны 2008 оны санхүүгийн тайланд эргэн үйлчлэх хэрэглээ бүхий заавал дагаж мөрдөх ёстой стандарт болно.
- СТОУС 12 Үйлчилгээний Концессийн Төлөвлөлт нь улсынхаас эхлээд хувийн үйлчилгээний концессийн төлөвлөлтөд зориулсан бүртгэлд үүсэх тайланд тусгах болон үнэлэхтэй холбоотой асуудлуудад заавар болно. Тус Банкны 2008 оны санхүүгийн тайланд заавал дагаж мөрдөх стандарт болох СТОУС 12 нь тус Банкны санхүүгийн тайланд аливаа нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа болно.
- СТОУС 13 Харилцагчдын Үнэнч Найдвартай Байдлын Программ нь өөрийн харилцагчид, үйлчлүүлэгчдийнхээ төлөө харилцагчдын үнэнч, найдвартай байдлын хөтөлбөр хэрэгжүүлдэг, эсвэл түүнд оролцдог аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн асуудлыг хөндөнө. Энэ нь үйлчлүүлэгч, харилцагч үнэгүй эсвэл хямдралтай бараа, үйлчилгээ гэх мэт шагналын кредит цуглуулах үйлчлүүлэгчийн үнэнч, найдвартай байдлын хөтөлбөртэй холбоотой. Тус Банкны 2009 оны санхүүгийн тайланд заавал дагаж мөрдөх стандарт болох

СТОУС 13 нь тус Банкны санхүүгийн тайланд аливаа нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа болно.

- СТОУС 14 НББОУС 19 – Тогтоосон Ашигт Хөрөнгийн хязгаар, Санхүүжилтийн минимум шаардлага, тэдгээрийн харилцан үйлчлэл нь тогтоосон ашигт хөрөнгөд холбогдох ирээдүйн хувь хэмжээний бууралт, нөхөн төлбөрийг ямар үед боломжтой гэж үзэх тухай тодруулахын зэрэгцээ тийм хөрөнгийн санхүүжүүлэлтийн минимум шаардлагуудын (СМШ) нөлөөний талаар зааврыг хангаж өгдөг. Мөн ямар үед СШМ өр төлбөрийг нэмэгдүүлж болох тухай асуудлыг хөндөнө. СТОУС 14 НББОУС 19 нь тус Банкны санхүүгийн тайланд ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа болно.

- Засварласан НББОУС 23 Зээлдүүлгийн өртөг нь зээлдүүлгийн өртгийг зарлагадах боломжийг хааж, үүнд холбогдох хөрөнгийг худалдан авалт, барилга байгууламж эсвэл үйлдвэрлэлтэй шууд холбоотой зээлдүүлгийн өртгийг тухайн хөрөнгийн зардлын нэг хэсэг болгон капиталжуулахыг шаарддаг. Тус Банкны 2009 оны санхүүгийн тайлагналд заавал дагаж биелүүлэх стандарт болох Засварласан НББОУС 23 нь одоогийн бодлоготойгоо нийцтэй тул бодлогын өөрчлөлт шаардахгүй.

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

	2007 мян.төг	2006 мян.төг
Касс дахь бэлэн мөнгө	27,117,737	25,371,639
Банкууд, бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	73,713,110	83,842,987
Монголбанк дахь үлдэгдэл	9,545,090	25,728,407
	110,375,937	134,943,033

Үлдэгдлийг Монголбанкнаас гаргасан шаардлагуудын дагуу Монголбанкинд байршуулдаг бөгөөд дансны үлдэгдэлд хүү тооцдоггүй. Үлдэгдлийг тооцоолохдоо татан төвлөрүүлсэн харилцах хадгаламж болон өр төлбөрийн дундаж үлдэгдэлд үндэслэдэг.

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн
тайлангийн тодруулга

5. Хөрөнгө оруулалтын үнэт цаас

	2007 мян.төг	2006 мян.төг
Төлөх хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас		
Монгол банкны үнэт цаас	35,540,155	22,428,915
Засгийн газрын үнэт цаас	4,724,555	802,981
Вексель	5,899,067	4,291,226
	46,163,777	27,523,122
Арилжаалах боломжтой хөрөнгө оруулалтын үнэт цаас		
Өмчийн үнэт цаас, өртгөөр	260,350	61,350
	46,424,127	27,584,472

6. Зээл ба урьдчилгаа

	2007 мян.төг	2006 мян.төг
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа	386,478,190	248,427,120
Ажилчдад олгосон зээл	2,979,822	3,423,345
	389,458,012	251,850,465
Зээлийн болзошгүй эрсдлийн сангийн хасагдуулга	(7,149,869)	(11,744,380)
Цэвэр зээл ба урьдчилгаа	382,308,143	240,106,085

Жилийн хугацаанд зээлийн болзошгүй эрсдлийн сангийн хасагдуулгын хөдөлгөөн доор үзүүлсний дагуу байна.

	2007 мян.төг	2006 мян.төг
Зээлийн болзошгүй эрсдлийн сангийн хасагдуулга		
1 сарын 1-нд	11,744,380	12,183,074
Жилийн төлбөр хураамж	942,360	1,446,565
Буцаан бичсэн/буцаасан	(4,568,511)	(1,522,280)
Данснаас хасагдсан	(814,817)	(43,659)
Бусад	(183,195)	-
Ханшийн зөрүү	29,652	(319,320)
12 сарын 31-нд	7,149,869	11,744,380

7. Хоёрдогч өглөг

	2007 мян.төг	2006 мян.төг
Улаанбаатар хотын банкинд олгосон зээл	4,000,000	-

Уг зээл нь жилийн 8 хувийн тогтсон хүүтэй. Уг зээл 2012 оны 9 сарын 25-нд 100 хувь эргүүлэн төлөгдөнө.

8. Үндсэн хөрөнгө

	Барилга	Ажлын байрны тоног төхөөрөмж тээврийн хэрэгсэл	Компьютер	Дуусаагүй барилга	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Өртөг/үнэлгээ					
Өртгөөр	1,118,290	1,309,142	1,257,936	-	3,685,368
Үнэлгээгээр	7,194,894	1,194,714	918,807	-	9,308,415
2007.01.01-ний байдлаар	8,313,184	2,503,856	2,176,743	-	12,993,783
Нэмэгдсэн	133,750	475,637	713,169	125,717	1,448,273
Худалдан борлуулсан	(436,451)	(196,515)	(36,209)	-	(669,175)
Данснаас хассан	(258,910)	(142,430)	(460,487)	-	(861,827)
Шилжсэн	950	4,767	-	(5,717)	-
2007.12.31-ний байдлаар	7,752,523	2,645,315	2,393,216	120,000	12,911,054
Төлөөлсөн зүйл:					
Өртгөөр	1,252,040	1,756,736	1,967,046	120,000	5,095,822
Захирлуудын үнэлгээгээр	6,500,483	888,579	426,170	-	7,815,232
	7,752,523	2,645,315	2,393,216	120,000	12,911,054
Хуримтлагдсан элэгдэл					
2007 оны 1 сарын 1-нд	207,928	161,339	399,004	-	768,271
Жилийн хураамж	244,770	414,982	569,221	-	1,228,973
Худалдан борлуулсан	(66,124)	(111,406)	(14,562)	-	(192,092)
Данснаас хассан	(21,500)	(97,346)	(458,739)	-	(577,585)
2007 оны 12 сарын 31-нд	365,074	367,569	494,924	-	1,227,567
Бүртгэлийн дүн					
2007 оны 12 сарын 31-нд	7,387,449	2,277,746	1,898,292	120,000	11,683,487

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн
тайлангийн тодруулга

	Барилга	Ажлын байрны тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	Компьютер	Дуусаагүй барилга	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Өртөг/үнэлгээ					
Өртгөөр	-	-	-	198,502	198,502
Үнэлгээгээр	7,243,911	1,354,637	938,843	-	9,537,391
2006.01.01-ний байдлаар	7,243,911	1,354,637	938,843	198,502	9,735,893
Нэмэгдсэн	14,061	1,309,142	1,257,936	905,727	3,486,866
Худалдан борлуулсан	-	(124,490)	(369)	-	(124,859)
Данснаас хассан	(49,017)	(35,433)	(19,667)	-	(104,117)
Шилжүүлсэн	1,104,229	-	-	(1,104,229)	-
2006 оны 12 сарын 31-нд	8,313,184	2,503,856	2,176,743	-	12,993,783
Төлөөлсөн зүйл:					
Өртгөөр	1,118,290	1,309,142	1,257,936	-	3,685,368
Захирлуудын үнэлгээгээр	7,194,894	1,194,714	918,807	-	9,308,415
	8,313,184	2,503,856	2,176,743	-	12,993,783
Хуримтлагдсан элэгдэл					
2006 оны 1 сарын 1-нд	-	-	-	-	-
Жилийн хураамж	212,198	296,881	418,675	-	927,754
Худалдан борлуулсан	-	(100,588)	(4)	-	(100,592)
Данснаас хассан	(4,270)	(34,954)	(19,667)	-	(58,891)
2006 оны 12 сарын 31-нд	207,928	161,339	399,004	-	768,271
Бүртгэлийн дүн					
2006 оны 12 сарын 31-нд	8,105,256	2,342,517	1,777,739	-	12,225,512

“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-ны хараат бус, мэргэжлийн үнэлээчдийн Банкны үндсэн хөрөнгөд хийсэн хамгийн сүүлийн үнэлгээний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Үнэлгээний огноо	Хөрөнгийн нэр	Үнэлгээний дүн мян.төг	Үнэлгээний арга
2005.12.31	Бүх үндсэн хөрөнгө	9,735,893	Зах зээлийн үнэ

Хэрэв үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдлийг хассан түүхэн өртгөөр бүртгэгдсэн бол дахин үнэлэгдсэн хөрөнгийн цэвэр дүн нь тайлант жилийн эцэст санхүүгийн тайланд дараах байдалтай тусгагдах байсан:

	2007 мян.төг	2006 мян.төг
Барилга	2,351,564	2,993,224
Ажлын байрны тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	665,505	1,040,189
Компьютер	288,441	677,402

9. Биет бус хөрөнгө

Өртөг	Программ хангамж, лиценз мян.төг	Гудвилл мян.төг	Нийт мян.төг
2007 оны 1 сарын 1	1,217,791	228,683	1,446,474
Нэмэгдсэн	400,235	-	400,235
Данснаас хассан	(18,989)	-	(18,989)
2007 оны 12 сарын 31-нд	1,599,037	228,683	1,827,720
Хорогдуулга			
2007 оны 1 сарын 1	387,849	228,683	616,532
Жилийн хорогдуулгын төлбөр	214,235	-	214,235
Данснаас хассан	(7,406)	-	(7,406)
